

“Гүнзгий мэд”

# MONGOLIAN ECONOMY



2015 оны 03 сар №06 (085)

ЭДИЙН ЗАСАГ

“МОНГОЛ ДАВОС”-ЫН ЗУРГААН НАСНЫ ЗУРЛАГА

Ч.ГАНХУЯГ: САЛХИ ХААШАА ОНГОЦ ТИЙШЭЭ  
ГЭЭД ЯВААД БАЙЖ БОЛОХ УУ

НИЙГЭМ

ЭЭ ДЭЭ, ЭНЭ ЭРЧҮҮД ҮҮ

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)



## ҮЗМЭР БОЛОХГҮЙН ТУЛД УРАГШЛАХ ХЭРЭГТЭЙ



# COAL MONGOLIA 2015



ANNIVERSARY

НҮҮРСНИЙ САЛБАРТ ХӨРВИГӨ ОРУУЛАГЧДЫН 5 ДАХЬ УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЭЭСГЭЛЭН






ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК



**MOST MONEY**  
ЭЛСЭЛТИЙН ХУРААМЖГҮЙ\*



**ОЛОН УЛСЫН КАРТЫН  
ХЯМДРАЛТАЙ,  
УРАМШУУЛАЛТАЙ ӨДРҮҮД**

**2015.05.31-нийг дуустал**

*\*Most Money үйлчилгээний хэрэглэгчдийн  
лимитийг ҮНЭГҮЙ өсгөнө.*

**692,000**

Монголчуудын дундаж цалин

**210,000,000**

Та тэтгэврийн даатгалаа 10% хүүтэйгээр  
30 жил хадгалахад үүсэх хуримтлал

**69**

Монгол хүний дундаж наслалт

**24,400,000**

Таны буцаан авах тэтгэврийн  
нийт хэмжээ

**137**

Хуримтлуулсан мөнгөө буцааж  
авахын тулд таны амьдрах ёстой жил

**ХУВИЙН ТЭТГЭВРИЙН ХАДГАЛАМЖ  
ТАНЫ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА**



Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

Монголын сэтгүүлдгийн эвлэлийн  
“2013 оны Шилдэг сэтгүүр”

## ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

## ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

## СЭТГҮҮЛИЙН РЕДАКТОР:

Б.Үүрийнтуяа

## АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Ийланд Роберт Мэн

## ВЭБ РЕДАКТОР:

Б.Энхцэцэг

## СЭТГҮҮЛЧИД:

Ц.Элбэгсайхан

Г.Орхон

А.Бүрэнжаргал

## МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Баранжав / 9409 2904

Б.Наранцогт / 9409 2905

## ХАЯГ:

Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг. I хороо,  
Энхтайвны өргөн чөлөө. Экспресс товер 11  
давхар 1101 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

Утас/Факс: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

www.ubprint.mn

## БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетийн бүх салбар

“Макс” супермаркетийн бүх салбар

“Фреско” супермаркет

ВТSI супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн

“Grand plaza”

“Metro mall”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр

“Max mall” дэх салбарууд

Монголын сэтгүүлчдийн эвлэлийн “2013  
оны Шилдэг сэтгүүр”

Монголын бизнесийн зөвлөлийн

“Бизнесийн салбарыг дэмжигч хэвлэл  
мэдээллийн байгууллага - 2012”

МҮХАҮТ-ын “2011 Оны Онцлох Хэвлэл”

РЕДАКЦИД  
ЗАХИАЛБАЛ  
ХҮРГЭЛТ  
ҮНЭГҮЙ



## БОРЛУУЛАЛТЫН ҮНЭ

# 18.000₮

## ЗАХИАЛГЫН ҮНЭ

НЭГ ДУГААР	15.000₮
УЛИРАЛ /6 дугаар/	90,000₮
ХАГАС ЖИЛ /12 дугаар/	180.000₮
ЖИЛ /24 дугаар/	360.000₮



## АГУУЛГА

### УУЛ УУРХАЙ

- 9 Үзмэр болохгүйн тулд урагшлах хэрэгтэй
- 11 Авлига дагуулсаар буй ашигт малтмалын лицензийн шалгаруулалт

### ЕРТӨНЦ

- 16 Агаарын тээврийн өчигдөр ба өнөөдөр

Р16



### ЭДИЙН ЗАСАГ

- 18 “Монгол Давос”-ын зургаан насны зурлага

Р18



Р22



**22 Ч.Ганхуяг: Салхи хаашаа онгоц тийшээ гээд яваад байж болох уу**

- 26 Урт хугацаанд хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэх боломж

Манай сайт руу зочилж, өдөр бүр эдийн засаг, бизнесийн талаар шинэ мэдээлэл аваарай.

### ЭДИЙН ЗАСАГЧДЫН БУЛАН

MongolianEconomy.mn/ дээр доорх **улаанаар тодруулсан** тэмдэгтүүдийг нэмээд холбогдох нийтлэлийг уншаарай.



Б.Эрдэнэбат

**Мэдлэг бол хүч ба Өвөр Монголоос төрсөн сэтгэгдэл**

Өвөр Монголын дөрвөн том их сургуульд очиж урилгаар лекц уншив. Сайхан монголчуудтай танилцлаа. Монгол улсад Солонгосын соёлын нөлөө их болж байгаа. Харин Өвөр Монголд Монгол улсынх маш их байдаг юм байна. Бидний уран зохиол, урлаг -

**mn/p/7176**



Ө.Ганзориг

**Хөшүүрэг**

Хүний үйл хөдлөлийг удирддаг Эдийн засгийн ба Философийн хөшүүргүүдийг өнөөдөр авч үзье. Нэг талдаа Хүн буруу зүйлд амархан уруу татагддаг, залхуу, амин хувиа хичээсэн, аймхай амьтан. Гэхдээ хүнийг эдгээр зан чанарууд нь нээлт хийлгэж -

**mn/p/7268**



Б.Дөлгөөн

**Хямралын гарц бол экспорт**

2015 оны босгон дээр Ерөнхий сайд Ч.Сайханбилэг хэлсэн үгэндээ Монголын эдийн засаг хямарлаа гэдгийг хүлээн зөвшөөрлөө. Эдийн засгийн тодорхойлолтын хувьд хоёр улирал дараалан эдийн засаг агшихыг хямрал гэж нэрлэдэг. Гэтэл 2014 оны арваннэгдүгээр сарын байдлаар -

**mn/b/7292**



Твиттер дээр биднийг дагаарай  
**@MN\_Economy**



Фэйсбүүк дээр бидэнтэй нэгдээрэй  
**Facebook.com/Mongolian.Economy**

Онлайн захиалга өгөхдөө  
**http://goo.gl/KVV50W** линкээр  
орох буюу энэ кодыг  
сканнердаарай:



## МОНГОЛД

### Эрчим хүч

Төвийн бүсийн эрчим хүчний тогтвортой байдлыг хангах, ОХУ-аас авч буй эрчим хүчийг багасгах үүднээс 315 мвт-ын хүчин чадалтай Эгийн голын усан цахилгаан станц барих ажлыг БНХАУ-ын буцалтгүй тусламжаар гүйцэтгэх болсныг Засгийн газрын ээлжит хуралдаанаар шийдвэрлэсэн байна. Ингэснээр Хятадын талд санал тавьж хэлэлцээр эхлүүлэх ажлыг Сангийн сайд, Эрчим хүчний сайд нарт даалгалаа. БНХАУ-аас ирэх нэг тэрбум ам.долларын буцалтгүй тусламжийн 827 сая ам.долларыг Эгийн голын усан цахилгаан станцын бүтээн байгуулалтад зарцуулах юм.

### Ам.доллар



Ам.долларын ханш өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 209 төгрөгөөр өссөн талаар Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсантай холбоотой гэдгийг мэргэжилтнүүд тайлбарлаж байна. Тодруулбал, ГШХО өнгөрсөн оны гүйцэтгэлээр 644.3 сая ам.доллар хүртэл буурсан нь 2013 оны мөн үетэй харьцуулахад 3.3 дахин багассан тоо юм.

### Орон сууц



Нийслэлд худалдаалж буй орон сууцны үнийн индекс сүүлийн долоон сар дараалан буурсан талаарх мэдээллийг “Тэнхлэг зууч” компанийн 4068 орон сууцад хийсэн судалгаа харуулж байна. Тухайлбал, өнгөрсөн хоёрдугаар сарын байдлаар орон сууцны үнэ өмнөх сарынхаас 0.5 хувь, өнгөрсөн оны мөн үеийнхээс 5.1 хувиар буурсан байна. Судалгаанд дурьдсанаар хуучин орон сууцны үнэ илүү буурсан аж. Мөн шинэ орон сууцны нэг ам.дөрвөлжин талбайн үнэ 2.15 сая төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2.3 хувиар буурсан үзүүлэлт. Түүнчлэн орон сууцны үнэд байршил хамгийн их нөлөөлж байна. Сүхбаатар дүүрэгт орон сууцны нэг ам.дөрвөлжин талбайн үнэ гурван сая гаруй төгрөг байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт 1.5 гаруй сая төгрөгийн үнэтэй байна.

### Түүхий эд

Монгол Улсын сайд М.Энхсайхан “Эрдэс баялаг 2025” хэлэлцүүлгийн үеэр “Эрдэс баялгийн салбар, супер цикл ба стратеги” илтгэлдээ “Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ 2011 онд хамгийн өндөр байсан. Гэхдээ Монгол Улс энэхүү супер циклийг ашиглаж чадаагүй” гэсэн юм. Тодруулбал,

сүүлийн 200 жилийн хугацаанд түүхий эдийн үнийн өсөлт, бууралт дунджаар 30-50 жилийн циклтэй явж иржээ. Иймд Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Б.Батхүрэлийн хэлснээр Монгол Улсын голлох түүхий эдүүдийн дэлхийн зах зээл дэх үнэ энэ онд өсөх хандлага ажиглагдахгүй нь.

### Боловсрол

Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын боловсролын солилцоо, хамтын ажиллагааны дагуу 2015-2016 оны хичээлийн жилд бакалавр, магистр, докторын сургалтад нийт 128 оюутныг тэтгэлэгээр сургахаар болжээ. Тус улсад байгаль орчин ногоон хөгжил, хөдөө аж ахуй, анагаах ухаан, эрүүл мэнд, уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, зам тээвэр, барилга хот байгуулалт, боловсрол, урлагийн чиглэлээр нийт 110, төрийн удирдлага, бизнесийн удирдлага, эдийн засаг, хууль болон хятад хэл судлалын чиглэлээр нийт 18 оюутан тэтгэлэгт хамрагдах боломжтой аж.


### Автозам



Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлаас нийслэл хүртэлх 32 км үргэлжлэх хурдны замын ажлыг энэ хавраас эхлүүлэхээр Засгийн газрын ээлжит хуралдаанаар шийдвэрлэлээ. Зургаан эгнээ бүхий нэгдүгээр зэрэглэлийн хурдны замын санхүүжилт болох 192 тэрбум төгрөгийн багагүй хувийг БНХАУ-ын буцалтгүй тусламжийн эх үүсвэрээс гаргах бол үлдсэнийг нь тус улсаас авах зээлийн санхүүжилт бүрдүүлэх юм байна. Мөн энэхүү хурдны замын төсөлд Бүгд найрамдах Польш улсын бизнесийн төлөөлөгчид хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлээд буй. Тодруулбал, замын санхүүжилтийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр, Европ стандартын дагуу барин хамтран ажиллах боломжтой гэдгийг тус улсын төлөөлөгч хэлжээ.

### Оюутолгой

2010-2014 онд Оюутолгой компанийн дотоодод зарцуулсан мөнгөн хөрөнгө:



## ДЭЛХИЙН МЭДЭЭ


### Хөрөнгө оруулалтын банкны амжилт



Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк Азийн зам тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо болон бусад дэд бүтцийн салбарыг дэмжих зорилготойгоор өнгөрсөн жил Бээжинд үйл ажиллагаагаа эхэлсэн. Тус банк АНУ-ын нөлөөнд байдаг Дэлхийн банктай өрсөлдөх хүчин болж байгаа юм. “Financial Times” сонинд мэдээлснээр АНУ тус банкыг байгуулах асуудлаар эсрэг байр суурьтай байсаар ирсэн. Гэвч Америкийн гол холбоотнууд болох Их Британи, Франц, Герман, Итали зэрэг орон тус банктай нэгдэх асуудлыг хүлээн зөвшөөрч буйгаа илэрхийлээд байгаа юм.

АДБХОБ-г үүсгэн байгуулснаар Хятад өөрийн “soft power” буюу зөөлөн хүчний бодлогыг бүс нутагт хэрэгжүүлэх боломжтой болно. Энэ нь АНУ-ын хувьд ашиггүй тусахаар байгаа аж. Сүүлийн жилүүдэд Хятад улс Төв Азиар дамнан худалдаа, дэд бүтцийн шинэ Торгоны замыг байгуулах хүсэлтэй байгаагаа мэдэгдэх болсон. АДБХОБ нь тус санаачилгыг санхүүжүүлэхэд гол

үүрэг гүйцэтгэх учиртай. Ройтерс агентлагийн мэдээлснээр Австрали, БНСУ тус банкны үйл ажиллагаанд нэгдэх асуудлыг хэлэлцэж байгаа ажээ. Харин Хятадын Ази дхь гол өрсөлдөгч Япон улс Азийн хөгжлийн банкны гол хувьцаа эзэмшигч тул АДБХОБ-д нэгдэн ажиллах магадлал бага аж. Монгол улс 2014



оны аравдугаар сард тус банкны хатман үүсгэн байгуулагч болохоор харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан.

### Путин Крымын талаар ам нээв

Оросын үндэсний телевизээр тус улсын Засгийн газрын захиалгат баримтат киног гаржээ. Уг кинонд ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путин Украйны Крымын хойгийн эзлэн түрэмгийлэх зарлигийг гаргасан тухайгаа өөрийн биеэр хүлээн зөвшөөрсөн байна. Тэрбээр Украйны ерөнхийлөгч асан Виктор Янукович Киевийг орхин гарснаас хэдхэн хоногийн дараагаар Оросын тусгай хүчнийхнийг Крымд оруулсан хэмээжээ. Тухайн үед Путин Крымын асуудалд Орос улс ямар ч хамаагүй гэж мэдэгдэж байсан юм. Крымыг эзлэх төлөвлөгөөг Путин

бүтэн шөнийн турш хэлэлцсэн тухайгаа ч Оросын ерөнхийлөгч хэлсэн байна. Зүүн Украйнд зөрчилдөөн үргэлжилсээр байгаа



бөгөөд үүний улмаас 6.0 мянга гаруй хүн амиа алдсан. Путин Оросыг дэмжигч, босогчдыг Кремль дэмжин турхирч байгаа гэсэн мэдээллийг эрс үгүйсгэжээ.

### “Рио Тинто”-гийн талаар

Англи-Австралийн уур уурхайн тэргүүлэгч компани “Рио Тинто”-гийн гаргасан жилийн эцсийн татварын тайланд түүхий эдийн үнэ буурсан ч тус компани нийт 7.1 тэрбум ам.долларын татварыг 2014 онд төлсөн гэжээ. Тус компанийн орлогын ихэнх хувийг төмрийн хүдрийн олборлолт бүрдүүлсэн бөгөөд түүхий эдийн ханш болон Хятадын илүүдэл нийлүүлтийг үл харгалзан баруун Австрали дахь төмрийн олборлолтоо нэмсэн байна. Тэдний 2014 онд төлсөн 7.1 тэрбум ам.долларын татвар болон роялтийн 80 хувь нь Австралийн төрийн болон холбооны Засгийн газрын санд орсон байна. Ийнхүү тус компанийн олон улсын татварын үр ашгийн хэмжээ 43 хувьд хүрчээ. “Рио

Тинто”-гийн санхүүгийн ахлах мэргэжилтэн Крис Линч “Бид татварын тайлангаа байнга танилцуулж байдаг нь татвар төлөлтийн ил тод байдлыг бүрэн дэмждэгийн баталгаа юм. “Рио Тинто” татвар хүлээн авагч улсууд, тэр дундаа Австралийн



эдийн засгийн гол хувь нийлүүлэгч байсаар байна” гэжээ. Тус компани 2014 онд 6.5 тэрбум ам.долларын ашиг олсон бөгөөд 2014 онд 185 сая ам.долларын татвар, роялтийг Монгол Улсад төлсөн байна.

### Гурвалсан уулзалт

БНСУ, Хятад болон Японы гадаад хэргийн сайд нар хамтын ажиллагаагаа сэргээх зорилгоор энэ сарын дундуур уулзалдлаа. Энэ нь Азийн тэргүүлэгч эдийн засгууд болох тус улсуудын сүүлийн гурван жилд хийсэн анхны уулзалт болохыг БНСУ-ын Гадаад хэргийн сайд онцлов. Хятад БНСУ, Япон улстай газар нутгийн маргаантай байгаа. БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын-Хе “Японы Ерөнхий сайд Шинзо Абэтай албан ёсны уулзалт хийгээгүй байгаа. Япон улс БНСУ чөлөөт ардчилал, эдийн засгийн зах зээлийн ижил зарчмыг баримталдаг чухал хамтрагч” гэжээ. ■

# COAL MONGOLIA 2015

НҮҮРСНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН 5 ДАХЬ УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЗЭСГЭЛЭН



ЗАСГИЙН ГАЗРЫН  
ДЭМЖЛЭГТЭЙГЭЭР:




ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:



ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:



МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, SS-CONVENTION CENTER, 2015 ОНЫ 4 САР 9-10



## COAL MONGOLIA-2015 ЧУУЛГАНД ҮЗЭСГЭЛЭН ГАРГАХ КОМПАНИУДЫН ТӨЛӨӨЛӨЛ



**ХААН БАНК**  
ЭРХЭМ ТАНЫ ИТГЭЛТ АНД



**EVERDIGM**  
EVERDIGM Mongolia LLC



**АМЖИЖ БҮРТГҮҮЛЭЭРЭЙ**

**БҮРТГЭЛ ЯВАГДАЖ БАЙНА**

[WWW.COALMONGOLIA.MN](http://WWW.COALMONGOLIA.MN)



976-70115590



[info@coalmongolia.mn](mailto:info@coalmongolia.mn)

## ХАНДЛАГА

# Үзмэр болохгүйн тулд урагшлах хэрэгтэй



## Б.ҮҮРИЙНТУЯА

Дэлхийн зах зээлд Монголын санал болгох уул уурхайн бүтээгдэхүүн бусдаас ялгараад онцгойроод байх зүйлгүй. Монголд олборлож байгаа алт Африкийнхаас илүү гэсэн баталгаа үгүй. Олборлож буй технологийн хувьд ч тэргүүлж гавихгүй байгаа. Тэгсэн атлаа бусдын тусламжийг авах дургүй, бусадтай хамтарч ажиллаж чаддаггүй бас бусдын өмнө хариуцлага хүлээж сураагүйгээсээ болж хөөж гаргасан хөрөнгө оруулагчдаа буцаад ирэхийг гуйгаад сууж байгаа гэхэд дэгсдүүлсэн болохгүй л болов уу. Үүнээсээ болоод нэг гараанаас эхэлсэн бусад өрсөлдөгч орноос хөгжлийн хувьд, сэтгэлгээний хувьд ч бас хоцрогджээ. Нээлттэй боломжоо ашиглаад, сул байдлаа давуу тал болгон эргүүлэх арга зам бидэнд дутагдаж байгааг Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Н.Алгаа хэлсэн. Эс бөгөөс Монголоор овоглосон салбар бүр “үзмэр” болоод үлдэх эрсдэл биднийг хүлээж байна.

Ийм зүйлтэй нүүр тулахгүйн тулд өрсөлдөхүйц татварын орчин, хувь хэмжээтэй байхын зэрэгцээ хүнд сурталыг аль болох бага байлгах замаар бизнес, тур дундаа уул уурхай хөгжих ажээ.

### МОНГОЛ УЛС УУЛ УУРХАЙН ОРОН МӨН ҮҮ?

Эдийн засагт оруулж буй хувь нэмрийг өндрөөр үнэлэн бодвол уул уурхайд түшиглэн хөгжих ёстой орнуудын нэг Монгол яах аргагүй мөнөөс мөн. Уул уурхайд

хамаарах бүхий л бүтээгдэхүүн моданд орж, уул уурхай улсын төсвийн 39 хувь, нийт экспортын 90 гаруй хувийг бүрдүүлж байсан “алтан үе” (2011-2012 он) дээрх асуултын тодорхой хариулт болно. Түүгээр ч зогсохгүй энэ онд л гэхэд тус салбар улсын төсөвт 16 хувийн хөрөнгө төвлөрүүлнэ гэсэн таамаг байна. Тэгэхээр уул уурхай манай улсын орлогын эх үүсвэр гэдэг нь батлагдах шиг. Гэвч эдийн засаг, хөгжлийн “таяг” нь болох учиртай энэ салбарт хэрэгжиж буй бодлого, хамарч буй газар нутаг болоод хууль эрх зүйн орчныг аваад үзэхээр нэг л төөрөлдөөд байгаа юм. Тухайлбал, дөрвөн жилийн тэртээ буюу нүүрсний үнэ 100 ам.доллар давж, дэлхийн уул уурхайн салбарынхан Оюутолгой, Монголын нүүрсээс өөр зүйл мэдэхгүй мэт ярьж байсан үед ашигт малтмалын хайгуулын лицензийн асуудлыг ихээр хөндөж, бүр зогсоож байлаа. Ашигт малтмалын тухай хуулиа хэт либерал, төрийн оролцоо хангалтгүй байна гэж үзсэн. Түүнчлэн Ашигт малтмалын хуулийн эхний хувилбарт Монгол Улсын нийт газар нутгийн 44 хувьд хайгуулын зөвшөөрөл олгоно хэмээн заасныг улсаа худалдсан хэрэг гэж зарлаад тус хувь хэмжээг долоон хувь хүртэл хумьсан байх юм. Ашигт малтмалын хуулийг машин гэж төсөөлвөл анх батлагдахдаа дөрвөн дугуйтай байж. Нэмж байна, өөрчилж байна, сайжруулж байна гэсээр тус хуулийг дөрвөн удаа хөндөхдөө дугуйг нь эхлээд дөрвөлжин, дараа нь бүр гурвалжин болгож орхисон

гэдгийг өнгөрсөн оны есдүгээр сард болсон “Эрдсийн бүтээгдэхүүний экспорт, өрсөлдөх чадвар: Жишиг үнэ” сэдэвт хэлэлцүүлэгт ирсэн салбарын төлөөллүүд дуу нэгтэй хэлж байсан. Дөрвөлжин дугуйтай машин хаа хүртэл явах вэ дээ. Мөн түшиц салбарыг маань хөрөнгө, санхүүжилтээрээ түшээ гэж байсан гадаадын хөрөнгө оруулалтаа “сайн дураараа” царцааж орхисон. Ингээд зах зээлийн үнийн хэлбэлзэл, уналт өсөлтийн мөчлөг гээчтэй золгож жилийн 17 гаруй хувиар дэлхийн рекорд тогтоож байсан эдийн засгийн өсөлт нь өдгөө долоон хувьд хүрч унасан төдийгүй гадаадын хөрөнгө оруулалт хэлэхэд ч харамсмаар хэмжээгээр буурчээ.

Хэдийгээр уналт, өсөлтийн мөчлөгийг урьдчилан таамаглах боломжгүй ч ийм үед дампуурчихгүйхэн шиг салбараа аргацаах бодлого, чадавх манай улсад алга. Хатуухан хэлэхэд энэ нь бидний хохь болж байгаа юм.

### НИРГЭСЭН ХОЙНО НЬ ХАШГАРААД НЭМЭРГҮЙ

Монголд зөвхөн уул уурхай асуудалтай байгаа биш аж. Хөгжил нь бусад салбартай харьцуулахад арай урд явж буй учраас л илүү их ярьж байна гэдгийг Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Н.Алгаа тайлбарлав. Тодруулбал, газар тариалангийн өгөөж нэмэгдэх үед тариа тарьдаг нь бүтээгдэхүүнээ чанартай гэж байхад талх хийдэг нь эсрэгээр нь ярьж, түүнд дургүйцсэн тариаланчдын зарим нь хайран

тариа, буудайгаа Төв талбай дээрээ асгаж тэмцэлдсэн. Энэ бүхний тайлал юу вэ гэхээр манай улсын аль ч салбарт зохицуулах бодлого байхгүй нь тод харагдаж байгаа юм.

Нэгэнт эхэлсэн уналтын мөчлөгийг давж гарахаас өөр зам бидэнд үгүй. Монгол Улсын Сайд М.Энхсайханы хэлснээр уул уурхайд тохиогоод буй сөрөг мөчлөг нэлээд олон жил үргэлжлэхээр харагдаж байгаа аж. Тэгвэл энэхүү бараан өдрүүдийг хэрхэн давах вэ гэдэг л асуудал болж байгаа юм. Байгалийн бүтээгдэхүүний дэлхийн ханш унасаар байгаа ч уул уурхайн бусад орнууд зах зээлээс “арчигдахгүй” байхыг хичээж буй. Дэлхийн хоёр дахь том эдийн засаг гэгдэх урд хөрш маань ч төрийн бодлого, татварын орчноо уян хатан болгох замаар дотоодын компаниудаа дэмжиж байна.

Манай улс дэлхийн зах зээлд жонш, зэс, нүүрс гэсэн гурван том багц бүтээгдэхүүн нийлүүлсээр ирсэн. Экспортын уламжлалт бүтээгдэхүүн гэх жонш өнөөдрийг хүртэл бартерийн худалдаагаар амь аргацааж ирсэн гэж болох аж. Нүүрс хар алт байхаа больж тонн нь 25 ам.долларт хүрч, худалдан авагч нь ховордсон. Зэсийн хувьд үнэ мөн л унасан. Ингээд экспортын гол бүтээгдэхүүний ханш буурмагц эдийн засаг хүндрээд ирэх нь мэдээж. Мөнгө өгье гээд “гуйдаг” байсан хөрөнгө оруулагчид ч дайжаад явчихна гэж тооцоолж сэтгээгүй улс төрчид мэдлэгт бус ашиг сонирхолд ялагдал хүлээгээд сууж байна. Энэхүү эдийн засгийн “шарх” дээр нэмээд популизм гэдэг ухагдахуун УИХ-ынхан дунд цэцэглэж төрийн ордонд “суудалтай” болоод авав. Улсын хөгжилд чөдөр болох тун ноцтой жор манай улсад сүүлийн жилүүдэд хүн бүрийн хоолны цэсэнд багтаж ирлээ. Н.Алгаа гуайн хэлснээр төр баялаг бүтээгчдээ дэмжих, бодлогогүй гаргасан хууль, дүрмээ багасгах, цуцлах арга хэмжээнүүд хэрэгжүүлэхээр хэрэндээ хичээж байгаа ч эдгээрээ хэрхэн гүйцэлдүүлэх учраа олохгүй явсаар байгаа юм. Тухайлбал, мөнгө олдог салбараа татварын орлого бүрдүүлэгч гэж үзсээр байгаа нь хамгийн том алдаа аж. Үүний нэг

тод жишээ бол Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр(АМНАТ). Тэнгэрийн хэмжээгээр тогтоосон жишиг үнэ өнөөг хүртэл татварын төлөвлөгөөт гүйцэтгэлийн шархаа нөхдөг аргачлал болж байгааг салбарынхан бүгд учирладаг. Дээрээс нь өмчид халдах, түүнийг үнэгүйдүүлэх оролдлого газар авч байгаа нь Монгол Улсад ямар ч салбар хөгжих аргагүй болгож байгааг харуулж байна. Тухайлбал, 106 гэж олонд танигдсан лицензийн асуудал уул уурхайн салбарыг “цус алдуулсан”. Учир нь 106 лицензийг цуцлана гэдэг 106 хөрөнгө оруулалтыг зогсоосонтой ижил. Олон жилийн хөдөлмөр нь хэзээ үнэгүйдэхийг мэдэхгүй тийм

“ **Үндэслэлгүй мэдээллээ мэдлэг гэж андууран өнөөдрийг хүрсэн нь манай улсад үүсээд байгаа болохгүй бүхний эхлэл гэж болох.** ”

орчинд ямар гэнэн этгээд мөнгөө цацаад байх талаар нухацтай бодох хэрэгтэй. Ийнхүү өөрсдөөсөө болж намагт шигдчихээд зах зээлийн үнэ, гараад явсан хөрөнгөтэй гадаадуудад хамаг буруугаа тохох гээд талцаад сууж байх аж.

Төр, түмэн нь бүгд салхинд хийсэх хамхуул байхаа больж тогтвортой арга зам эрэлхийлэхэд оюунаа чилээх цаг иржээ.

#### ТАТАХ ХҮЧ БУЮУ ГАРЦ

Монгол Улс зорилгогүй байна гэж нэр бүхий эдийн засагч, компанийн захирал, судлаачид хэлсээр. Уул уурхайн орон байх гээд байна уу, мал аж ахуйгаа эрхлэх гээд байна уу эсвэл аялал жуулчлалаар замнах гээд байна уу гэхээр тодорхой хэлээд өгчих хүн үнэндээ алга. “Яг юуг, яаж, хэзээ хийх вэ. Тэрийгээ хаана, яаж, хэнд зарж, хөрөнгөжин хөгжинө гээд байгаа нь тодорхойгүй” хэмээн “Ард санхүүгийн нэгдэл”-

ийн захирал Ч.Ганхуяг хэлжээ. Мөн “Санхүүгийн зах зээлийн холбоо”-ны захирал Ө.Ганзориг “Эдийн засгийн чадавхыг хэмждэг хамгийн гол хүчин зүйл бол бүтээмж. Улс орнууд хөгжлийн зорилго тавьдаг” гэсэн байна. Тэдний хэлж буйгаар манай улсад бүтээмж гэсэн зүйл алга. Зорилго ч үгүйлэгдэж байгаа гэлээ. Энэ асуудалд Н.Алгаа “Төрийн захиргааны чадавхын асуудлыг хөндөх хэрэгтэй. Олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн систем, стандарт үгүйлэгдэж байна. Асуудал бүхэн сөрөг зүйл биш. Гагцхүү аль болох түргэн шийддэг байх хэрэгтэй. Мөн сайн мэргэжилтэн, залгамж халаа гэдэг зүйл дутмаг байна. Алдаа гаргасан бол түүнээсээ суралцах холбоос алга. Тэгэхээр бүх түвшний байгууллагууд нэгдсэн хүсэл эрмэлзэл, нэгдмэл зорилготой болж ажиллах шаардлагатай” гэсэн юм. Эргэж, буцдаг буруу зуршлаасаа салаагүй тохиолдол уул уурхай намагт гүн шигдсээр байх гэнэ. Хөрвөөж, хөдлөх тусам улам шигддэг нь намгийн гол аюул. Иймд улс төрийн тогтворгүй байдал, татварын зохисгүй бодлого үргэлжилсээр байвал байдал сэргэх цагаар бид хаана байсан тэндээ маргалдсаар байх дүр зураг бууж байна. Түүнчлэн баялгийн хараал, популизм хүрээгээ тэлэхэд дөрөв дэх засаглал түлхэц болж байгааг дурьдахгүй байхын аргагүй. Тэнцвэрт мэдээлэл гэхээсээ илүү хаана сенсаци байна түүнийг мэдээлдэг болсон нь хүн бүрийн ярьж буй ч бүрэн ойлгохгүй байгаа популизм гээчийн ургах хөрсийг бэлдэж буй томоохон хүчин зүйл болж байгааг Н.Алгаа онцлон хэлсэн юм.

Үндэслэлгүй мэдээллээ мэдлэг гэж андууран өнөөдрийг хүрсэн нь манай улсад үүсээд байгаа болохгүй бүхний эхлэл гэж болох. Бодит үнэнийг бодолцож эхэлсэн цагт мэдлэг рүү тэмүүлэх гарц бий болох учиртай. Ингэхийн тулд төр, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, иргэд гээд Монгол Улс гэсэн нэр дор аж төрж буй хэн бүхэн дор бүрнээ өөрчлөгдөх хэрэгтэй байгаа аж. Тодруулж хэлбэл, иргэн иргэн байхаа больж, төр төр байхаа болиод байгааг хувийн хэвшлийн төлөөллүүд учирласаар байгаа билээ. ■

ТЭД БИДНИЙ ТУХАЙ

# Авлига дагуулсаар буй ашигт малтмалын лицензийн шалгаруулалт

ТЭРРЭНС ЭДВАРДС



Хоёрдугаар сарын нэгэн өглөө н.Баатарын утас дуугарч “Чи хэр хурдан шивдэг билээ?” гэж түүний авга ах яарангуй асуув. Дөрвөн жилийн турш зогсоод байсан ашигт малтмалын олборлолтын лицензийг дахин олгох тогтоол гарч, өргөдөл хүлээн авч эхэлсэн нь энэ байж. Ийнхүү лиценз олгохтой холбоотойгоор цахим өргөдлийгаль болох түрүүлж өгөх гэж яарсан уул уурхайн олон бизнес эрхлэгчийннэг Баатарын авга ах байлаа.

Баатар гэх нэр эх сурвалжийн маань жинхэнэ нэг биш. Учир нь тэрбээр авга ахынхаа компанид саад учруулахыг хүсээгүй тул өөрийн нэрийг нууцлахыг хүссэн юм. Баатар технологийг “жинхэнэ утгаар” нь эзэмшсэн, компьютер дээр маш хурдан шивдэг ч түүний чадварууд авга ахад нь тус болж чадсангүй. Яагаад гэвэл Монголын Ашигт малтмалын газар (АМГ) аль хэдийнээ өргөдөл хүлээн авч дууссан байлаа. Баатар Засгийн газрын ашигт малтмалын олборлолт хийхээр заасан газруудын талаар хэлэхдээ “Олон сонголт байгаа ч заасан газруудад олборлолт хийх эрх хүсэгчдийн тоо хэт их байсан. Өргөдлийг маш түргэн бөглөсөн ч хангалттай хурдан байж чадаагүй бололтой” гэсэн юм. Баатарын хэлж буйгаар авга ахынх нь компани хөрөнгө ихтэй бас технологийн чадавх өндөртэй компаниудад дарагдсан байж болох ч улс төрийн “арын хаалга” учир шалтгаан болох

бүрэн үндэслэлтэй гэдгийг учирлав.

Монголын Засгийн газар 2010 онд ашигт малтмалын, тэр дундаа алт, зэсийн олборлолт хийх лиценз олголтыг хориглосон. Гэвч гадаадын хөрөнгө оруулалт дахин татахын тулд Монголын Засгийн газар уг шийдвэрээ улирагч онд цуцалсан билээ. Өнгөрсөн онд Монголын эдийн засгийн өсөлт 7.8 хувь хүртэл буурсан. Энэ нь тийм ч муу үзүүлэлт биш боловч гурван жилийн өмнөх дэлхийд тэргүүлж байсан 17.5 хувийн өсөлттэй харьцуулахад тун бага тоо юм. Эдийн засгийн өсөлт ийнсаарсан нь Монголын төр хөрөнгө оруулагчидтай тохиролцоонд хүрч чадахгүй байгаатай холбоотой аж. Улмаар дэлхийн анхаарлын төвд ороод байсан Монголын ашигт малтмал, уул уурхайн салбар хөрөнгө оруулагчдын хүлээлгийн жагсаалтад ороод буй.

Ашигт малтмал олборлох эрхийг дахин олгох болсон нь Монголын Засгийн газар тус салбарын үйл ажиллагааг сэргээх гэсэн оролдлого ажээ. Гэсэн ч хөрөнгө оруулагчдын сонирхолыг хүссэн хэмжээндээ татаж чадаагүй нь тэд бүтэлгүйтсэнийг илтгэж байгаа бололтой. Хэдийгээр Монгол Улсын Засгийн газар 10.1 сая га газарт олгогдох ашигт малтмалын лицензийн сонгон шалгаруулалт ил тод, нээлттэй байх тухай удаа дараа мэдээлсэн ч гадаадын хөрөнгө оруулагчдын зүгээс сонгон шалгаруулалт шударга бус өрнөж

буй хэмээн төрийн мэдэгдлийг эрс няцаасан.

## ЭХНИЙ ӨДРӨӨСӨӨ Л АСУУДАЛ ДАГУУЛАВ

Цахим хэлбэрээр зарласан сонгон шалгаруулалт авлигыг цэглэх чухал үзүүлэлт гэж байсан ч лиценз олголтын бүхий л явцшудрага бус, хэсэг бүлэг хүмүүст илүү ашигтайгаар зохион байгуулагдсан хэмээн хөрөнгө оруулагчид гомдоллож байна.

Уул уурхайн яамны дэд сайд асан О.Эрдэнэбулган өнгөрсөн есдүгээр сард “bne IntelliNews”-д өгсөн ярилцлагадаа 2015 онд Монгол Улс ашигт малтмалын лицензээс 1.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт авах бололцоотой хэмээж байжээ. Харин хөрөнгө оруулагчдын үзэж буйгаар дээрх лицензүүд үнэ хүргэж дамлан зарах сонирхол бүхий этгээдүүдийн гарт очих магадлал өндөртэй аж. Монголын талаас дамлагч, чанаргүй хөрөнгө оруулагчдыг хязгаарлах үүднээс тендерт оролцох компаниудад өндөр шалгуур тавьсан гэнэ. Тухайлбал, оролцогч гэмт хэрэг болон татварын асуудалгүй байх, Нийгмийн даатгалын газар зэрэг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагуудад өр төлбөргүй байх, ашигт малтмалын олборлолт эрхлэхийн тулд шаардлагатай хөрөнгийг банкны дансанд байршуулах зэрэг шалгуур заажээ. Гэвч эдгээр өндөр шалгуурыг өргөдөл хүлээн авч эхлэхээс хэдхэн хоногийн өмнө цуцалсан байна. Энэ талаар нэрээ нууцлахыг хүссэн нэгэн компани “bne IntelliNews”-д дотоодод өрнөж буй мэдээллээс хуваалцахдаа “Тавьсан шалгууруудаас үүдэн үймээн гарсан бөгөөд Монголын Ашигт малтмалын газар шалгуурын заалтуудаа цуцлахаас өөр аргагүй байдалд хүрсэн” гэсэн юм.

Монголын Ашигт малтмалын газар урдчилан сонгосон газруудын лицензийн өргөдлийг өнгөрөгч нэгдүгээр сараас эхлэн авсан. Гэвч цахим хуудсын техникийн асуудал хөрөнгө оруулагчдыг ихээр бухимдуулжээ. Өнгөрсөн нэгдүгээр сарын 26-ны өглөө эхний өргөдлүүдийг хүлээн авч эхэлсэн бол эхний 10 минутын турш цахим хуудас ажилгаагүй болсон тухай хөрөнгө оруулагчид ярьж байв. Өргөдөл хүлээн авч эхэлснээс 19 минутын дараагаар вебсайт руу нэвтрэх боломжгүй болжээ. Мөн эхний 30 өргөдлийг хүлээн авснаас хойш өргөдөл мэдүүлэх боломжгүй болсон нь гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдыг ихэд “гомдоосон” хэрэг болсон юм. Үүнтэй холбоотойгоор програм хангамжийн компаниуд өргөдөл хүлээн авах мэдээллийн сангийн батгаамжийг нэмэгдүүлэн өргөтгөх саналыг Монгол Ашигт малтмалын газарт хүргүүлсээр байж. Улмаар эхний 120 өргөдлийг хүлээн авах боломж бүрдсэн ч минут хүрэхгүй хугацаанд дээрх тоо гүйцсэн аж.

Сонгон шалгаруултад оролцсон уул уурхайн нэгэн компанид ажилладаг мэдээллийн технологич залуугийн хэлснээр дээрх програм хангамжийн нэг хэсгийг хэрхэн ашиглахаа тэрбээр мэдэж байсан бөгөөд тухайн програмыг дөрвөн сая төгрөгөөр, мөн нэг өргөдөл бүртгүүлэхэд 500 мянган төгрөгийг АМГ-т төлсөн тухайгаа нэмж өгүүлсэн юм. Тэрбээр “Хууль бус гэж үзэхгүй байгаа ч зөрчлийн асуудал байгааг үгүйсгэхгүй” гэв.

Өргөдөл гаргагчдын гомдлын мөрөөр Монголын Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас АМГ-ын лиценз олгох өргөдөл хүлээн авах үйл явцыг шалгаж нятлах тухайгаа мэдэгдсэн ч дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй гэсэн юм. Энэ асуудлаар Монголын Ашигт малтмалын газраас мэдээлэл авахыг хүссэн боловч тодорхой хариу өгсөнгүй.

#### ХАВЦАЛЫН ИРМЭГ ДЭЭРХ НЭР ХҮНД

Хөрөнгө оруулагчдын хувьд

өргөдөл хүлээн авах ажлын явц амлаж байсан шинэ эхлэл бус харин ч хуучны явцгүй үйл ажиллагаа үргэлжилсээр байгааг харууллаа. Монгол Улсын бизнес эрхлэх орчин авлигын атганаас салж чадахгүй байсаар. Санал асуулга явуулах үйлчилгээгээр дагнадаг “Сант Марал” сан 2014 оны гуравдугаар сард авлигын талаарх тайлангаа гаргасан байна. Тус судалгаагаар үүнд оролцсон хүмүүсийн 30 хувь нь авлига шударга бус дүрэм журмыг давахад тусалдаг гэсэн бол 38 хувь нь хүнд сурталыг давахад хэрэгтэй гэж үзсэн байна.

Монголын бизнесийн орчин нэр хүндээ алдаад байна. Монголын Засгийн газар, “Рио Тинто” хоорондын 130 сая ам.долларын (одоо 30 сая ам.доллар болж буурсан) татварын асуудал өнөөг хүртэл үргэлжилж буй.

Уул уурхайн салбарын асуудал Монголын Засгийн газрын толгойн өвчин болж байгаа нь мэдээж. Тэгвэл зарим хөрөнгө оруулагч Монголын Засгийн газар шинэчлэлт хийнэ гэдэгт итгэж байгаа. ■

## СУДАЛГАА

# Монгол болон Төв Азийн хувьцаанд нөлөөлөх тавааруудын үнийн хэлбэлзэл

Э.ЭНЭРЭЛТ /Азийн хөгжлийн банкны Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн/

Өнгөрсөн хугацаанд дэлхий даяар эрчим хүч, металлын хэрэглээ огцом өсч ирсэн. Эрдэс баялгийн түүхий эд, эрчим хүчний эрэлтийн өсөлтийн гол хэсгийг БНХАУ болон Энэтхэг улс бүрдүүлж байна. Тус хоёр улс 1990-2004 онд дэлхийн газрын тосны эрэлтийн өсөлтийн 40 хувийг дангаараа бүрдүүлж, эрэлтийн жилийн өсөлт нь долоон хувьтай тэнцэж байв. Энэ нь уул уурхайн түүхийн эд экспортлогч хөрш зэргэлдээ орнуудад эдийн засгийн тааламжтай байдлыг бий болгож байсан юм. Тус бүс нутагт олборлож байгаа уул уурхайн үндсэн түүхий эдэд газрын тос, зэс, алт, уран, төмрийн хүдэр, молибден, нүүрс, газрын ховор элемент зэргийг нэрлэж

болно.

Төв Ази болон Монгол Улсын байгалийн баялаг дэлхийн эрчим хүчний аюулгүй байдал, түүхий эдийн зах зээлд цаашид чухал үүрэг гүйцэтгэх төлөвтэй байна. Гэвч энэхүү давуу тал эдгээр улсыг түүхий эдийн зах зээлээс хэт хамааралтай болгосон. Иймд эдийн засгийг төрөлжүүлэхэд анхаарах зайлшгүй шаардлага тулгарч байна. Үүнийг хэрэгжүүлэхэд эдгээр орны гадаадын хөрөнгө оруулалтын орчин, засаглалын сул байдал гол бэрхшээл болж байна. Газрын тос болон уул уурхайн гаралтай түүхий эдийн үнэ 2008 онд огцом унасан. Энэ нь экспортын цөөн тооны түүхий эдээс хамааралтай Төв Азийн орнуудын эдийн засагт сөргөөр нөлөөлсөн.

Улмаар эдгээр улсын дийлэнх нь дэлхийн санхүүгийн хямралын үеэр эдийн засгийн уналтад орсон. Казахстаны эдийн засгийн өсөлт 2007 онд 8.9 хувь байсан бол 2009 онд 1.2 хувь болтлоо буурч, Монгол Улсын ДНБ-ий өөрчлөлт нь 2009 онд -1.3 хувьтай гарсан юм.

Сүүлийн 200 жилд ашигт малтмалын мөчлөгийн өсөлтийн үе дунджаар 16 жил үргэлжилж байжээ. Үүнээс сүүлийн зуун жилд өсөлтийн үеийн дундаж хугацаа 13.6 жил байжээ. Харин уналтын үе нь 20 гаруй жилээр үргэлжилж байсан байна. Хямралын үед түүхий эд, ашигт малтмалын үнийн уналт, хөрш орнуудын эрэлт буурсанаас үүдэн Төв Азийн орнуудын төсвийн алдагдал

нэмэгдэж, экспорт огцом буурч, аж үйлдвэрийн салбарын эргэлт удааширч байсан юм.

Өнөөгийн газрын тос, түүхий эдийн зах зээлийн хэлбэлзэл нь Төв Ази, Монголын үнэт цаасны ханшид сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай байгаа нь Бусад оронд хийсэн судалгааны үр дүн Газрын тос, бусад ашигт малтмалын үнэ нь Төв Азийн эдийн засагт нөлөөлөгч чухал хүчин зүйлс юм. Тухайлбал, Казахстан, Узбекистан, Туркменистан улс газрын тос, байгалийн хийн экспортоороо бүс нутагтаа тэргүүлэгч орнууд юм.

Ази тивээс үүдэлтэй эрчим хүч, түүхий эдийн эрэлтийн хурдацтай өсөлт нь хөрөнгийн зах зээлийг газрын тос болон бусад түүхий эдээс улам бүр хамааралтай болгож байна. олон улсын хөрөнгийн биржүүдэд бүртгэлтэй Төв Ази болон Монголын компаниудын дийлэнх хувийг уул уурхай, ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд эзэлж байна. Иймд олон улсын зах зээл дээр арилжаалагдаж буй Монгол, Төв Азийн орнуудын хөрөнгийн үнэ цэнэ газрын тос, ашигт малтмалын зах зээлээс шууд хамааралтай болж байгаа юм. 1970-аад оны газрын тосны зах зээлийн уналтын дараа газрын тос, алтны үнийн хэлбэлзэл нь судлаачдын анхаарлын гол бай болсон. Хэд хэдэн эмпирик судалгаанд алт, газрын тосны зах зээлийн үнийн огцом өөрчлөлтийн нөлөө нь АНУ, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнууд (ОЕСД) болон бусад улсад хүчтэй байсныг тогтоосон байдаг.

### СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ КОМПАНИУД ГАЗРЫН ҮНИЙН ӨСӨЛТӨӨС АШИГ ОЛДОГ

Ихэнх судалгаанд газрын тос болон хувьцааны хооронд орших эерэг хамаарлыг харуулсан байдаг. Гэхдээ цөөн тооны судалгаанд урвуу хамаарлыг тооцсон байна. Учир нь газрын тосны ханшийн огцом өсөлт нь бусад салбарын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх хандлагатай байдаг. Жишээ нь тээврийн зардлыг өсгөх, үйлчилгээг илүү үнэтэй болгох гэх мэт. Харин сэргээгдэх эрчим хүчний компаниуд газрын тосны үнийн өсөлтөөс ашиг олдог болох нь



эмпирик судалгаагаар тогтоогдсон байна. Учир нь сэргээгдэх эрчим хүч бол газрын тос болон уламжлалт эрчим хүчний эх үүсвэрийг орлох бараа юм.

### ГАЗРЫН ТОСНЫ ҮНИЙН ӨСӨЛТ МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН ХУВЬЦААНЫ ҮНЭД ХЭРХЭН НӨЛӨӨЛДӨГ ВЭ?

Ер нь газрын тос, ашигт малтмал нь хөрөнгийн зэх зээлд харилцан адилгүй нөлөө үзүүлдэг. Энэ нь тухайн түүхий эдийн төрлөөс хамаарч байдаг. Судлаач Рамос, Вега (2011) нарын судалгаагаар зарим түүхий эдийн үнийн өөрчлөлт (хөнгөн цагаан, зэс, какао, шиш, этилен, пропилен) нь аж үйлдвэрийн салбарт тэгш бус нөлөөтэй гарсан байна. Энэ нөлөө нь газрын тосны салбарын хувьцааны хувьд эсрэгээр илэрч байжээ. Торонто, Лондон болон Хонконгийн бирж дээр арилжаалагдаж буй Монголын болон Төв Азийн уул уурхайн 12 компанийн хувьцааны өгөөж, түүхий эдийн ханшийн нөлөөг судлахад уул уурхайн компаниудын хувьцаанд үзүүлэх газрын тосны олон улсын зах зээлийн ханшийн нөлөө статистикийн хувьд өндөр ач холбогдолтой гарсан. Уул уурхайн компаниуд бол шатахуун, газрын тосны үндсэн хэрэглэгчид.

Коксжуулсан нүүрс, зэс, алтны үнэ нь Төв Ази, Монголын уул уурхайн компаниудын хувьцааны үнэтэй шугаман хамааралтай байдаг. Энэ нь компаниудын хувьцааны үнийн өөрчлөлт тавааруудын ханшаас өндөр хамааралтай байдаг гэсэн үг юм. Харин газрын тосны ханшийн хөрөнгийн үнэд үзүүлэх


нөлөөлөл нь шугаман бус юм. Олон улсын зах зээл дээрх газрын тосны үнэ огцом өсөхөд Монгол болон Төв Азийн компаниудын хувьцааны ханш эхэндээ даган өсдөг. Харин дунджаар хоёр долоо хоногийн дараа хувьцаа буурах хандлагатай байдаг байна. Олон улсын хөрөнгө оруулагчид хувьцааны зах зээлийн өгөөж, хүүгийн өнгөрсөн болон одоо үеийн хөдөлгөөнийг анхааралтай ажигладаг. Дээрх жишээнээс үзвэл уул уурхайн компаниудын хувьцаа, газрын тосны үнийн хооронд шугаман бус, тогтворгүй хамаарал оршиж байна.

Газрын тосны үнийн бууралт нь Монгол болон Төв Азийн газрын тосны бус чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцаанд аажимдаа таатай нөлөө үзүүлэхээр байна. Харин Казахстан зэрэг газрын тос экспортлогч оронд таагүй зүйл юм. Бусад түүхий эдийн ханшийн хэлбэлзэл нь тэдгээр компанийн орлогын өөдрөг таамаглалыг бууруулахад хүргэж байгаа юм. Энэ оны нэгдүгээр сард Дэлхийн банкнаас гол ашигт малтмалуудын үнийн таамаглалыг бууруулсан. Тухайлбал, энэ онд Австрали нүүрсний үнийн таамаглал нэг метр тонн бүрт 75-67 ам.доллар, нэг баррель газрын тосны үнэ 95.7-53.2 ам.доллар, нэг метр тонн зэсийн ханш 6880-6550 ам.доллар байна гэж үзжээ. Иймээс бизнесийн хүлээгдэж буй мөнгөн урсгалын хэмжээ буурах нь хувьцааны ханшид сөрөг нөлөө үзүүлдэг. Энэхүү эмзэг байдлыг арилгахын тулд эдгээр оронд эдийн засгийн бусад салбарыг хөгжүүлж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг үргэлжлүүлэн дэмжих хэрэгтэй байна. ■

# 2014 оны Өмнөговийн худалдан авалт


## 77 ТЭРБУМ ТӨГРӨГ

Өмнөговийн худалдан авалт  
(тэрбум төгрөг - жилээр)



Өмнөговь аймагт бүртгэлтэй 100 гаруй ханган нийлүүлэгч "Оюу толгой"-д бараа, үйлчилгээ нийлүүллээ.

Худалдан авалт, төрлөөр  
(тэрбум төгрөг)

-  Барилга, угсралтын ажил  
1.5 тэрбум төгрөг
-  Тээвэр  
26.7 тэрбум төгрөг
-  Үйлдвэрлэлийн хэрэглээний материал  
30 тэрбум төгрөг
-  Үйлчилгээ  
4 тэрбум төгрөг
-  Засвар, хэрэглээний материал  
9.6 тэрбум төгрөг
-  Машин, механизм  
5.6 тэрбум төгрөг




"Оюу толгой" компанийн худалдаж авсан бүтээгдэхүүн, үйлчилгээ бүр нь Өмнөговийн аж ахуйн нэгжүүдэд хөгжил дэвшил, шинэ технологи, ур чадвар, аюулгүй ажиллагаа, үр ашигтай байдлыг авчирдаг. "Оюу толгой" худалдан авалтаараа ажлын байр бий болгож, орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж байна.

# 8/10

## 10₮ тутмын 8₮-ийг Монголд зарцуулж байна

Үндэсний худалдан авалтын өсөлт  
(хувиар-жил тутам)



Монгол улсад бүртгэлтэй, Монгол улсын иргэн компанийн 50-иас дээш хувийг эзэмшдэг үндэсний ханган нийлүүлэгчдээс нийт худалдан авалтын 50-иас дээш хувийг гүйцэтгэж байна. Нийтдээ худалдан авалтын 80-иад хувийг Монгол улсад бүртгэлтэй, татвар төлөгч дотоодын аж ахуйн нэгжүүдээс авч байна.

Худалдан авалт, төрлөөр  
(тэрбум төгрөг)

-  Барилга, угсралтын ажил  
13.9 тэрбум төгрөг
-  Үйлдвэрлэлийн хэрэглээний материал  
45.5 тэрбум төгрөг
-  Шатах, тослох материал  
138.6 тэрбум төгрөг
-  Үйлчилгээ  
163.6 тэрбум төгрөг
-  Суурин тоног төхөөрөмж  
5 тэрбум төгрөг
-  Засвар, хэрэглээний материал  
98.1 тэрбум төгрөг
-  Машин, механизм  
22.9 тэрбум төгрөг
-  Тээвэр  
54.3 тэрбум төгрөг



“Оюу толгой” компани нээлттэй, ил тод, бизнесийн ёс зүйтэй худалдан авалтын үйл ажиллагааны үр дүнд найдвартай, тогтвортой, өрсөлдөхүйц үнэ бүхий ханган нийлүүлэлтийн дотоодын сүлжээ бий болгож ирсэн бөгөөд ингэснээр ажлын байр бий болгож, Монгол улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж байна.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

# Агаарын тээврийн өчигдөр ба өнөөдөр



## Б.ЭНХМӨНХ

Та онгоцоор нисэхээс айдаг уу? Айж байна уу? Хаа нэгтэй осолдчих болов уу хэмээн бодож байсан удаа бий юу?

Тэгвэл салбарын судлаачдын үзэж байгаагаар бол бид иргэний нисэхийн хамгийн аюулгүй үед амьдарч байгаа аж. Гэвч өнгөрсөн оны байдлаар агаарын тээврийн ослоор 700 гаруй хүн амь үрэгдсэн гэсэн тоо гарчээ. Тухайлбал, Малайзын МН 370 онгоцор сураггүй алга болсон бол тус компанийн МН 17 нислэг Украины нутаг дэвсгэр дээр осолдсон харамсалтай хэрэг гарсан. Эдгээрээс төд удалгүй Алжирын “Air Algerie 5017” цөлд унаж, зорчигчид, нислэгийн багаас нэг ч хүн амьд үлдээгүй билээ. Саяхан хүртэл Малайзад бүртгэлтэй “Air Asia” компанийн QZ8501 нислэг далайд осолдож 162 хүний амийг авч одсон. Ердөө 138 өдрийн дотор энэ бүгд болж өнгөрсөн бөгөөд үүний улмаас 700 гаруй зорчигч, нислэгийн

багийнхан золгүй ослоор алтан амиа алдсан. Энэ явдал агаарын тээврийн аюулгүй байдалд эргэлзэхэд хүргээд буй. Дэлхий нийт улирсан он нисэхийн салбарт хамгийн халтай жил байв уу хэмээн асууж байна.

Нислэгийн аюулгүй ажиллагааны сүлжээний статистик мэдээлэлд 2014 онд иргэний агаарын тээврийн 12 осол гарч, улмаар 761 хүн мөнх бусыг үзүүлсэн гэсэн тоо дурьджээ.

Вашингтоны Нислэгийн аюулгүй ажиллагааны байгууллагын Олон улсын төслийн захирал Руди Кэвздо хэлэхдээ “Ослын давтамжийн талаарх мэдээлэл цуглуулах бүрэн боломжтой ч нягтлахын тулд машиных хүч хөдөлмөр, цаг хугацаа зарцуулна” гэсэн юм. АНУ-д 2001 онд “American Airlines” компанийн 587-р нислэг Нью-Йорк хотын Бэлл Харборын ойролцоох Квинсийн гудамжинд осолдож 265 хүн амь үрэгдсэн явдлаас хойш тийм хэмжээний томоохон осол гараагүй

ажээ.

Иргэний агаарын тээвэрт хамгийн халтай жилээр 1972 он хэмээн бүртгэсэн байдаг. Тус онд 2429 хүн нисэх онгоцны ослоор нас баржээ. Тухайлбал, ОХУ-ын Аэрофлотын 217-р нислэг төдийгүй Испанид унасан Конвэйр 990 онгоцны осол маш олон хүний амийг авч одсон байдаг. Сүүлийн жилүүдийн мэдээллээс үзэхэд нисэхийн салбарт том хэмжээний ослын тоо харьцангуй багассан аж. Тус тооцоог гаргахын тулд нисэх урсгалыг хянах мэргэжилтнүүд дэлхийн бүхий л онгоцны буудлаас ирж, очих нийт онгоцны тоог гаргадаг байна. Үүний дараагаар нийт нислэгийн тоог тухайн жилд гарсан ослын үзүүлэлтэд хувааж тухайн жилийн индексийг тайлагнадаг юм байна. Тухайлбал, 2013 онд 1.0 сая нислэгийн дунджаар 0.24 хувь нь осолдох магадлал гарч байжээ. Энгийнээр хэлбэл, тус онд онгоц

осолдох магадлал нэг буюу түүнээс бага байсан гэсэн үг. Вашингтоны Нислэгийн аюулгүй ажиллагааны байгууллагын Олон улсын төслийн захирал Руди Кэвэдо “Энэ үзүүлэлт том хэмжээний осол гарах магадлал маш бага гэдгийг нотолж байна” гэсэн юм. Тэгвэл Швейцарын “Aviation Advocacy” стратегийн зөвлөх фирмийн удирдах зөвлөлийн дарга Андро Чарлтон “Онгоцоор зорчигчдын хувьд нисэхээс илүү аюултай зүйл нь онгоцны буудал руу машинтайгаа явах” гэжээ.

Хамгийн их амь эрсдэж байсан жилүүдэд дэлхийд томоохонд тооцогддог ослоуд багтаагүй байдаг нь хачирхалтай. Тухайлбал, 1977 онд Испанийн Тенериф арлын агаарын зурваст нисэж байсан хоёр онгоц мөргөлдөж 583 хүн амь үрэгджээ. Харин 1946 оноос хойших “хамгийн аюулгүй жилүүдэд” жилд 11-21 осол гарч 224-627 хүн амь насаараа хохирсон гэсэн баримт байна. Кэвэдо “Осол гарахгүй байна гэдэг боломжгүй зүйл гэж бодож байна. Гэхдээ аюулгүйн байдлаас харвал засаж, залруулах зүйлс үргэлж гардаг. Агаарын тээврийг илүү найдвартай болгох боломж бас шаардлага бий” гэсэн байна.

Мэргэжилтнүүд нисэхийн салбарын таагүй үзүүлэлт буурсаар байгаа нь техникийн дэвшил, холбоо харилцаа сайжирсан, мөн smart буюу ухаалаг үйл ажиллагаа, удирдлагын систем нэвтэрсэнтэй холбон тайлбарлаж байна.

Дэвшилт технологи олон сая хүний аюулгүй зорчих тасалбар болж байгааг Кэвэдо учирлав. Тэрбээр “Аюулгүй байдлаас авч үзвэл иргэний тээвэрт зориулан зохион бүтээсэн нисэх онгоц гэнэтийн аюул, тухайлбал пуужингаас зайлж бултах зориулалттай биш. Иймд энэ төрлийн халдлагаас үүдсэн ослоос улбаалж тус салбарын аюулгүй байдалд эргэлзэх, ямар нэг дүгнэлт гаргах нь учир дутагдалтай” хэмээн онцолжээ. Түүний хэлснээр олон улсын иргэний агаарын тээврийн салбарын үйл ажиллагаа тогтвортой явж буй аж.

Өнгөрсөн жилүүдэд иргэний агаарын тээврийн салбар дуулиант бас таагүй мэдээллээс хол тойроогүй. Гэхдээ энэ онд байдал өөрчлөгдөж салбарын хувьд

чихэнд чимэгтэй мэдээ дуулгах бололтой. Тухайлбал, шинэ Airbus ашиглалтад орох бөгөөд Airbus A350 XWB загварын онгоц 2015 оны арванхоёрдугаар сарын 22-нд анхны захиалагчдаа очиж 2016 оны нэгдүгээр сард зорчигчдоо хүлээн авах аж. Тус онгоц аэродинамикийн хувьд далавчаахамгийн үр дүнтэйгээр ашиглаж чаддаг болсон байна. Түүний анхны захиалагч болох “Qatar Airways” компани онгоцоо ирэх арванхоёрдугаар сард хүлээн авах юм байна.

Түүнчлэн шинэ загварын Боинг 787 онгоц захиалагчдынхаа гарт очсон төдийгүй дараачийн загвар болох Боинг компани 787-10 загвараа 2018 оноос гаргах төлөвлөгтэй байгаа аж. ■



МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН-2015

# “Монгол Давос”-ын зургаан насны зурлага


И.ОТГОНЖАРГАЛ

## “ИТГЭЛЦЭЛ” ТОЙРСОН АСУУДЛУУД

Монгол Улсын хөгжлийн тухай яриа хэлэлцүүлэгт одоогоос зургаан жилийн өмнө шинэлэг санаачилга, шинэ өнгөөр хүч түрэн орж ирсэн нэгэн арга хэмжээ бол Монголын эдийн засгийн форум. Тус чуулган ирэх дөрөвдүгээр сарын 2-3-нд Төрийн ордонд зургаа дахь жилээ болох гэж байна. Төр, засаг, хувийн хэвшил, иргэний нийгэм, олон улсын байгууллагын, гадаадын хөрөнгө оруулагчдын төлөөлөл болох дунджаар 600-800 хүн цуглан чуулдаг уламжлалтай. Энэ жил ч тогтсон жишгээрээ болно. Харин хэзээнээс бүртгэл явагдаж, ямар сэдвийн дор хэрхэн өрнөх бол гэсэн сураг ажиг хүмүүст бий. Жил бүрийн гуравдугаар сарын дундуур болдог байсан уламжлал нь энэ удаа арав гаруй хоногоор хойшлоод буй. Энэ нь зохион байгуулагчдын зүгээс төр, засгийн төлөөллийг аль болох олноор нь оролцуулах гэсэн хүсэл сонирхолтой холбоотой. Учир нь, Их хурлын чуулганы ээлжит завсарлага таарч, УИХ-ын гишүүд тойрогтоо ажиллаж байгаа нь эдийн засгийн чуулган болдог тогтсон цаг хугацааг эвдэх нэг шалтгаан болжээ. Нөгөө талаас гуравдугаар сард ХБНГУ-д болдог “ITB Берлин-2015” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол Улс анх удаа албан ёсоор түнш орноор оролцож, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн цөөнгүй хүн тус арга хэмжээг зорьсон нь бас нэгэн харгалзаж үзэх шалтгаан байжээ. Хэлэлцэх асуудлын тухайд энэ жил Монголын макро эдийн засгийн орчин тун тааруу, Хөрөнгө оруулалт бараг байхгүйтэй адил шахуу болсонтой холбоотой Монголын нэр хүнд гадаад ерөнцөд

сайнгүй байгаа, дотооддоо тэнгэрт хадсан ам.долларын ханштай эвлэрсэн, Шийдлийн Засгийн газрын тэргүүний ард түмнээсээ санал авч, зоримог хөдөлгөх гэсэн мега төслүүд урагшлахгүй гацсан хэвээр байгаа зэрэг асуудал бий учраас эдийн засгийн чуулганд оролцогчдод хэлэх ярих, нөгөө талаас төр, засгийнхнаас ч сонсох, шалгаах шийдлийн чанартай зүйл их бий нь ойлгомжтой. Тийм ч учраас Монголын эдийн засгийн форум ТББ-ын зүгээс энэ удаагийн чуулганыг “Итгэлцэл” уриан дор өрнүүлэхээр бэлтгэж байна. Энэ нь нэг талаас алсарсан хөрөнгө оруулалтыг татах, нөгөө талаас монголчууд маань дотооддоо бие биендээ итгэх итгэлээ сэргээгээсэй гэдэг утгыг илэрхийлж байгаа гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл аливаа бизнес ч бай, улс төр ч бай, хоёр хувь хүний хоорондын харилцаа ч тэр ямар ч асуудал итгэлцлээс эхэлдэг болохоор Монгол Улсын өнөөдрийн урвайсан царайтай байгаа хөгжлийн цовхийг дээшлүүлэхэд итгэлцэл хэрэгтэй гэсэн үг. Энэ хүрээнд эдийн засаг, бизнесийн олон асуудлыг ярихаар төлөвлөсөн байна. Гаднын зочид төлөөлөгчдийг ч өмнөхийн адил урьжээ. Тухайлбал, Азийн хөгжлийн банкны дэд ерөнхийлөгч Стэффинс Графф, БНСУ-д байрлах Дэлхийн ногоон хөгжлийн хүрээлэн олон улсын байгууллагын ерөнхий захирал Иво де Боер нарын зочин ирэх аж. Мөн Монгол Улсын сайд М.Энхсайхан мега төслүүдийн талаар илтгэл тавих бол Оюутолгой, Тавантолгойн асуудал ч яригдаж таарна. Монголын эдийн засгийн чуулган-2015 болохтой холбоотой мэдээллийг хүргэлээ.

Харин одоо зургаан настай золгож буй Монголын эдийн засгийн форум өнгөрсөн таван жилд нийгэмд



2012 оны Монголын эдийн засгийн чуулганы зочин Итай Талгам

ямархан ач холбогдолтой зүйлийг бий болгов гэдгийг эргэн харъя. Яагаад энэ талаар өгүүлэх ёстой вэ гэвэл бүтэн таван жилийг өнгөрөөх



2013 оны Монголын эдийн засгийн чуулганы зочин  
Голландын Ерөнхий сайд асан Вим Кок



2014 оны Монголын эдийн засгийн чуулганы  
зочин Дэлхийн эдийн засгийн форумын стратеги  
хариусан дарга Кристел Вандер Елст

нь нийтлэлийн эхэнд хэлсэнчлэн шинэ санаачилга, шинээр нэвтрүүлсэн арга хэмжээний хувьд ач холбогдол, үр дүн талаас

нь харахад нэгийг хэлж, хоёрыг сануулах цаг хугацаа. Ялангуяа сэтгүүлчид зохион байгуулагчдаас эдийн засгийн форумын үр дүн юу

байх вэ хэмээн асуух нь олонтаа. Мөн зургаан жилийн өмнө тус чуулганыг анх “мэндлэхэд” цаашаа хэр удаан үргэлжилж, тогтмол үйл ажиллагаатай байж чадах болов уу гэсэн болгоомжлол ч зарим хүнд байсан байх.

Тэгвэл энэ чуулган нийгэмд юу өгч чадсан бэ? Нэгдүгээрт, дотоод, гадаадад Монголын эдийн засгийн чуулган гэдэг нэр хүндийг бий болгож чаджээ. Нэг үгээр, хөгжлийн асуудлаараа нийгмийн олон талын оролцоог ханган чуулж, тэр нь дотоод, гадаад ертөнцөд хүрдэг. Жил бүрийн чуулган болох цаг хугацааг хүлээдэг, энэ жилийн хурлаар ямар асуудлыг хэлэлцэх бол ирэх жилийнхээр ийм асуудлыг хэлэлцээсэй гэсэн бодол хүсэл нийгэмд байдаг. Энэ нь Монголын эдийн засгийн форумыг улам өргөжин тэлээсэй гэсэн нигмийн хүлээлт болов уу. Форумын бүртгэл нь цахим хэлбэрээр олон нийтэд нээлттэй болдог ч гэлээ байр савны багтаамжаас хамаарч оролцогчдын тоонд хязгаар тавигддаг тул хэн хүссэн бүхэн нь энд оролцоод байж чаддаггүй. Нөгөө талаасаа нэр хүндийн хэрэг юм.

### МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН ШУУД АРДЧИЛЛЫН НЭГ ХЭЛБЭР

Мөн нийгмийн нэр нөлөө талаас нь авч үзвэл төрийг хувийн хэвшлийн, олон нийтийн санаа бодлыг сонсдоггүй, асуудлыг нээлттэй бусаар хэлэлцэн баталж, хэрэгжүүлдэг. Ингэснээр амьдралд буухгүй шийдвэр, дүрэм гаргадаг гэж нэлээд шүүмжилдэг. Тэгвэл уг чуулганыг 2010 оноос жил бүр хийдэг уламжлал тогтсоноос хойш дээрх шүүмжлэл тодорхой хэмжээгээр багассан гэж хэлж болно. Монголын эдийн засгийн чуулганы гол зорилго нь төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, олон улсын байгууллагын, гадаадын хөрөнгө оруулагчдын төлөөллийн оролцоог хангаж, тэдний санаа бодлыг сонсох, үнэтэй санал санаачилга, зөвлөмжийг төрийн бодлого тодорхойлогчдод хүргэхэд чиглэдэг. Төр, засгийн хүмүүсийг хоёр өдрийн хуралдаанд аль болох олноороо сууж, асуудлыг тэвчээртэй сонсоосой гэж хүсдэг, мөн тэднээс

хөгжлийн бодлогын талаар тодорхой шийдэл сонсохыг хичээдэг. Түүнчлэн зохион байгуулалтын хувьд хуралд оролцогчид тулгамдсан асуудлуудаа сөхөж, болохгүй бүтэхгүйгээ ярьж гомдоллохыг чухалчилдаггүй. Харин болгохын төлөө юу хийх вэ гэдгээ хэлэлцэж, хөгжлийн загвараа гаргахыг зорьдог. Хууль боловсруулагчид, бодлого тодорхойлогчдын төлөөллийг индэрт урин залж байгаад чуулганы зочид асуудаг, бас шүүмжилдэг. Энэ бол шууд ардчиллын нэг хэлбэр гэж тус чуулганы талаар үнэлэлт дүгнэлт өгөх зарим нь хэлдэг. Чуулганы хувьд тухайн иргэн, хувийн хэвшлийнхэн, гаднын байгууллагынхан улс орны хөгжилд өөрийн дуу хоолойгоо хүргэх, санаа бодлоо илэрхийлэх боломжийг бүрдүүлж өгч байдгаараа давуу талтай. Хоёр өдөр төрийн төлөөлөл аль болох бага ярьж их сонсох, хол, ойрын зочин гийчид санаа оноогоо уралдуулж, бусад орны хөгжлийн туршлагаас судалж, хамтдаа хөгжих замаа засаж, дэлхийн жишигтэй хөл нийлүүлэн алхахын тулд “Монгол Давос” төрж, зургаан нас хүрээд байна. Тэр ч утгаараа чуулган анх зохион байгуулагдахаас эхлээд Дэлхийн эдийн засгийн форумын төлөөлөл ирж оролцохоос гадна 2013 онд “Голланд өвчнийг” “Голланд гайхмашиг” болгож чадсан Нидарландын ерөнхий сайд асан Вим Кок, 2014 онд Дэлхийн эдийн засгийн форумын Стратеги хариуцсан ахлах дарга Кристел Вандер Елст тэргүүтэй төлөөлөгчид ирж, Монголын 2040 он хүртэлх хөгжлийн зураглалын талаар илтгэл тавьж, зөвлөгөө өгч байсан. 2011 оны чуулганы нэгдсэн хуралдааныг хөтөлсөн CNN-ийн олон улсын сурвалжлагч Стан Грант Монголын эдийн засгийг “Чоно эдийн засаг” хэмээн томъёолсон ч удаатай.

Таван жилийн хугацаанд давхардсан тоогоор тус чуулганы төлөөлөгч болох олон мянган хүн төрд үгээ хэлж, түмэнд саналаа дуулгасан. Гагцхүү түүнийг нь сонсоод, бодлого шийдвэртээ тусгаж ажиллах учиртай төр, засгийн хүмүүсээс оролцогчид хааяа үр дүн нэхэх нь бий. Харин зохион байгуулагч төрийн бус байгууллагын зүгээс нийгмийн сэтгэхүйд шинэ зүйлийг нэвтрүүлэх, хайрцагласан

санаанд гарц нээж өгөх, улсын хөгжлийн талаар нээлттэй хэлэлцэх талбарыг бий болгодог. Форумд төлөөлөгчид хэр идэвхтэй оролцож, үгээ хэлж байгаа нь хурлын үр дүн гэж харж ч болох. Өнгөрсөн хугацаанд хэлэлцсэн сэдвүүдийг аваад үзэхэд тоймгүй. Тухайлбал, 2011 онд “Хүний хөгжил”, “Хөгжлийн бодлого”, “Засаглал”, “Дэд бүтэц” гэсэн дөрвөн үндсэн сэдвээр 15 салбар хуралдаан өрнөсөн бол 2014 онд 30 гаруй сэдвээр хэлэлцсэн.

Харин бүх хэлэлцүүлэг нь монгол хүнд, тодруулбал монгол хүний сурч боловсрох, ажиллаж, амьдрах сайхан орчныг хэрхэн бүрдүүлэхэд чиглэж байсан 2011 оны хуралдааны

ярьсан. Шинэчлэлийн Засгийн газрын тэргүүн Н.Алтанхуяг “Бид хийж бүтээж сурахгүй бол мөнхөд циркийн амьтан, торны шувуу шиг үлдэх болно” хэмээн өнгөрсөн оны форумын үеэр уриалж байв. Тэрбээр 2013 оны чуулганаар “Үндэстэн бүхэнд брэнд байдаг. Тэгвэл Монгол ямар нэрээр танигдах боломж байна вэ гэхээр “Монгол бол натурал” байгалийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг орон гэдгээр дэлхийд танигдах ёстой” гэж учирлаж байсан. Мөн “Энэ чиглэлээр хувийн хэвшил юу хийж чадахаар байна, төр дэмжлэг үзүүлэхэд бэлэн” хэмээн амлаж байлаа. Энэ хүрээнд ч бондын мөнгийг 888 төсөл зэрэгт

**“ Таван жилийн хугацаанд тус чуулганы төлөөлөгч болох олон мянган хүн төрд үгээ хэлж, түмэнд саналаа дуулгасан. Гагцхүү түүнийг нь сонсоод, бодлого шийдвэртээ тусгаж ажиллах учиртай төр, засгийн хүмүүсээс оролцогчид хааяа үр дүн нэхэх нь бий. Харин зохион байгуулагч төрийн бус байгууллагын зүгээс нийгмийн сэтгэхүйд шинэ зүйлийг нэвтрүүлэх, хайрцагласан санаанд гарц нээж өгөх, улсын хөгжлийн талаар нээлттэй хэлэлцэх талбарыг бий болгодог. ”**

хоёр дахь өдрийн чуулганыг нээж Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж үг хэлэхдээ “Ашигт малтмал зөвхөн хөрсөн дээр мөрөө үлдээдэг биш, хүний хөгжилд мөрөө үлдээх ёстой” хэмээн тэмдэглэсэн нь хэн бүхний санаанд тодхон үлдсэн санагдана. Манай сэтгүүл ч гэсэн тус чуулганы дараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн “Хүн чанар ажилд авна”, “Халуун мөнгө”, “Уул уурхайн орлогоороо урлаг соёлоо услая”, “Нүүрээ угаа” зэрэг нийлэл бичиж байлаа. Засаглал, хүний хөгжил, дэд бүтэц, уул уурхайн орлогын тухай өнөөдөр ч бид ярьсаар л байгаа. Эдгээр нь хөгжлийн тухай асуудал учраас жил жилийн эдийн засгийн чуулганаар тогтмол хөндөгддөг сэдвүүд хэвээр байна. 2013 онд шинэчлэлийн Засгийн газрын үед Монгол брэндийг бий болгох асуудлыг, 2014 онд эдийн засгаа төрөлжүүлж, дархлаа тогтоохын тулд Монголдоо бүтээцгээе гэсэн уриан дор хөгжлийн асуудлаа

чиглүүлсэн гэж үзэж болох.

Харин энэ удаагийн эдийн засгийн чуулганаар ярих асуудал, гарах бүтээлч санал санаачилгыг шийдлийн Засгийн газрын тэргүүн Ч.Сайханбилэг хэр сонсож, хүлээж авч, бодлого шийдвэртээ тусгах бол. Өмнөх Засгийн газрын тэргүүнүүд форумаар хэлэлцсэн асуудлуудыг бүгд хэрэгжүүлсэн гэвэл худлаа, гэхдээ хэрэгжүүлээсэй гэдгийг хуралд оролцсон хүн бүр хүсдэг, хүлээдэг. Төлөөлөгчдийн зүгээс чуулган зохион байгуулагч Монголын эдийн засгийн форум төрийн бус байгууллагыг ч нэг хэлэлцүүлээд орхих биш, чуулганаар яригдсан асуудлыг төр, засагт байн байн сануулдаг байнгын үйл ажиллагаатай байгаасай гэж хүсдэг. Зургаан жилийн өмнө төрж, хөл дээрээ тэнцэж, үйл ажиллагаагаа тогтвортой явуулж буй “Монгол Давос-2015”-д амжилт хүсье. ■



## МИНИЙ ЗОЧИН

# Ч.Ганхуяг: Салхи хаашаа онгоц тийшээ гээд яваад байж болох уу

Д.БЭХБАЯР

“Ард санхүүгийн нэгдэл”-ийн гүйцэтгэх захирал Ч.Ганхуягтай санхүүгийн зах зээл, эдийн засгийн өнөөгийн байдал, хөгжлийн асуудлаар гарц шийдэл хайн ярилцлаа.

**-Өнөө жилийн Эдийн засгийн форумын үндсэн агуулгыг итгэлцэл сэдвээр хийхээр төлөвлөжээ. Гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, тэдний итгэлийг олж авахад анхаарал хандуулна гэж байна. Итгэлийг алдах амархан, олох хэцүү гэдэг. Итгэлийг яаж эргэн олж авах юм бэ?**

-Мэдээж итгэлийг олж авах тухай ярихаас гадна хамгийн гол нь үйлдлээрээ харуулах нь чухал. Тухайлбал, том төслүүдийг хөдөлгөх хэрэгтэй. Тавантолгой, Оюутолгойн төслүүдийг явуулж, төмөр замаа баръя. Бид алдаагаа ухамсарласан, эргээд ирээч, одоо бидэнд итгэж болно гэж мянган удаа хэлээд ч хэцүү. Итгэл олж авах эхний алхам бол хүлээгдэж байгаа том төслүүдийг хөдөлгөх.

Нөгөө талдаа Эдийн засгийн форумын ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байгаагийн хувьд надад нэг санаа байгаа. УИХ-ын сонгууль болоход нэг жил л үлдлээ. Ямар аюул харагдаж байна вэ гэхээр үлдсэн нэг жилд улстөржсөн байдал газар авахаар байна. Гэтэл өнөөдөр улсын эдийн засаг, аж ахуйн нэгжүүд, ард иргэдийн амьдрал ямар байгаа билээ. Улстөржилт, популизм хоёр улс орныг, иргэдийг сайн зүйлд аваачихгүй. Улстөржилтийн тухай ганцхан би биш олон хүн ярьж байна. Гадаадын хөрөнгө оруулагчид ч хүлээлтийн байдалтай байгаа шүү дээ. Тэд хөрөнгө оруулж, төсөл хэрэгжүүлэхээ түр азнаа, сонгуулийн жилийг, сонгуулийн дүнг харъя. Дараа нь асуудлыг шийдье гэсэн байдлаар хандаж байна.



Тэгвэл энэ жилийн форумын зорилго нь хүлээнэ, дараагийн сонгуулийн үр дүнг харна гэсэн зүйл байхгүй. Бид боломжтой бүх асуудлыг шийднэ. Сонгууль ийм хууль дүрмээр явна, намууд хоосон амлалт өгөхгүй, олон нийтэд таалагдах популизм хийхгүй. Манай улс дунд хугацааны хөгжлийн зорилго чиглэлээ тодорхойлсон. Бид улстөржих хана, хязгаараа босгосон, тэр дунд л улстөржилт явах болно. Бусад том төслөө явуулна, төмөр замаа барина, засаг солигдсон ч

хөгжлийн ерөнхий бодлогоо барьж ажиллана гэж улстөрийн намууд ярилцаж, зөвшилцөөд гарын үсэг зурах ёстой. Энэ бол эдийн засгийг хүндрэлээс гарах, хөгжлийг сэргээх том хүчин зүйл болно. Ийм үр дүнд хүрч чадвал хамгийн том ач холбогдолтой форум энэ жилийнх болно гэж үзэж байгаа.

**-Дотоодын эдийн засгийн хямралтай, уруу байдлыг та яаж харж байна вэ?**

-Өнөөдрийн үүссэн хямралыг гадаад зах зээлээс болсон гэж

тайлбарлаж өөрсдийгөө өмөөрөх хэрэггүй. Мэдээж улстөрчид ингэж ярина. Миний бодлоор алдааг дотроосоо хайх хэрэгтэй. Дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ өсөхөөр Монголын зах зээл өсдөг, түүхийн эдийн үнэ унахаар манайх савалж, хямардаг гэж жолоодлогогүй усан онгоцонд суусан юм шиг ярьж болохгүй байх. Салхи хаашаа онгоц тийшээ гээд яваад байж болох уу. Хүмүүс аль тэртээх зуунаас дарвуулт онгоцыг салхитай байсан ч өөрийн хүссэн, төлөвлөсөн цэг рүүгээ залж очиж, ирсэн шүү дээ.

Тэгэхээр төр өөрсдийн арчаагүй байдлаас болж гаргасан алдаагаа бусдад нялзааж, өөрсдийгөө уснаас цэвэр гаргах гэж хичээх хэрэггүй юм. Бид алдаагаа харж, зөв онош тавьж, эмчилдэг систем рүү богино хугацаанд ормоор байна. Эдийн засгийг төрөлжүүлэх талаар олон жил ярилаа. Сайшандад парк, тэнд төмөр зам барина гэж хий хоосон байдлаар бус судалгаа баримт, шинжлэх ухааны үндэслэл дээр тулгуурлаж ярьж, бодит ажил болгоход анхаармаар байна. Ер нь манай улс хөгжлийн концепц, ямар нэг төрийн шийдвэрийг бодит судалгаа дээр үндэслэж гаргадаг болмоор байна. Судалгааны институциудыг дорвитой ажиллуулъя. Асуудалд цээжний пангаар хандаж, хоосон популизм хийдэг өнөөдрийн байдал нь биднийг салхи хаашаа онгоц тийшээ явдаг жаахан хүүхдийн тоглоом шиг болгож хаялаа. Хүүхдүүд цаасаар онгоц хийж үлээгээд шидэхээр үлээсэн зүг рүүонгоц нь хийсэж унадаг биз дээ. Үүнтэй адил.

Монгол Улс өнөөдөр хөгжлийн жанжин шугам, чиггүй явж байна. Манайх 20 жилийн дараа ямар улс болох вэ хэмээн асуувал би нэг өөр, чи бас өөр, Их хурлын гишүүд 76 өөр зүйл ярина. Өөрөөр хэлбэл, монгол үндэстнийг нэгтгэсэн нэг зорилго тэмүүлэл алга. 800 жилийн өмнөх өвөг дээдсээрээ бахархаад л, зарим нь энэ том бахархлыг улстөржүүлэн Их хурлын сонгуульд ялах зорилго дэвшүүлж байна. Тэгэхээр бид хамгийн түрүүнд улс орны хөгжлийн зорилго, түүнд хүрэх арга замаа тодорхойлж, арга замынхаа дээд доод хязгаарыг тогтоогоод тэр хоёр

хязгаар дотроо ажиллаж амьдрах ёстой. Нэг туйл нь монголчуудыг бараг л 800 жилийн өмнөх байдал руугаа эргэн оруулж, интернэт, мэдээллийн технологигүй орчинд очих нь зүйтэй гэх, нөгөө нь дан ганц аялал жуулчлал, эсвэл монгол хүний хосгүй оюун ухаанаар хөгжүүлнэ гэдэг туйлаас гарах шаардлагатай. Эрүүл хүний нүдээр хөгжлийг зөв олж харж, оношлоод эмчлээд явмаар байна.

**-Улсаа эхлээд нарийн мэргэжлийн оношлогоонд оруулаад хаа хүрэх гээд байгаа хөгжлийн чигээ тодорхойлоод явъя гэж салбар салбарын олон мэргэжилтэн судлаачид яриад л байгаа. Яаж бодит ажил болгох вэ?**  
-Дэлхийн эдийн засгийн

**“ Монголын хамгийн өндөр үнэлгээтэй, хариуцлагатай, өгөөжтэй, хүлээлттэй, ил тод, нээлттэй, хувьцаат компанийг бий болгоно гэж төлөвлөж байна. ”**

форумын хурал семинарт оролцоод явахдаа нэг зүйлийг анзаарсан. Тэнд эхлээд шинжээч судлаачдыг суулгаж байгаад асуудлаа танилцуулж, мэтгэлцээн явуулдаг. Манай урд хөрш орны хөгжлийн амжилтыг хар. Хятадууд улс орныхоо хөгжлийн бодлоготой холбоотой асуудлаарх хуралд Их дээд сургуулиудынхаа эрдэмтэн профессоруудыг урьж оролцуулдаг. Профессорууд нь хөгжлийн бодлого ярьдаг. Төрийн түшээд нь сонсдог, үйл ажиллагаа, шийдвэртээ тусгаж авдаг зарчим Хятад улсад үйлчилдэг. Монгол Улстай хэрхэн харилцах тухай хэлэлцээрт Бээжингийн их сургуулийн профессор орж ирээд суух жишээний. Энэ нь Хятадын төр засаг Их дээд сургуулиудын эрдэмтэн доктор, эрдэм шинжилгээний ажилтнуудынхаа судалгаа дээр тулгуурлан шийдвэр гаргаж ажилладаг гэдгийг харуулж байгаа юм.

Гэтэл манайд эрдэмтдээ, судалгаа шинжилгээний байгууллагуудынхаа хийсэн зүйлсийг харж, сонсч, ашигладаг бил үү. Судалгаа шинжилгээний институциуд олон бий ч ажилгүй хүмүүс тэдгээр судалгааны байгууллагыг байгуулчихсан юм шиг тэдний үг, судалгааг тоолгүй өнөөг хүрсэн. Төрийнхөн зөвхөн УИХ-ын хэдэн гишүүний үгийг сонсдог. Ийм учраас Монгол Улс дэлхийн зах зээл дээр хамгийн өндөр огцом өсөлттэй, эсвэл өсөлттэй эдийн засгаа огцом нурааж популизм хийж байгаа улсаар тодроод байгаа хэрэг.

Популизмын тухай Баабар сайтар бичсэн байна лээ. Монгол улсын үндэсний аюулгүй байдалд муугаар заналхийлж буй зүйл. Улс орноо сүйрүүлтэл популизм хийсэн улсууд байдгийг улстөрчид анхаарах хэрэгтэй юм.

**-Улс орны хөгжлийн бас нэгэн том тулгуур санхүү, хөрөнгийн зах зээлийг нэн түрүүнд хөгжүүлэх шаардлагатай. Харин манайд банкны салбарын хөгжил давамгайлсан байдалтай. Хэрхэн яаж санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх вэ?**

-Жижиг зах зээлд банкны үйлчилгээ 95 хувийг эзэлж байна. Хөрөнгө санхүүгийн зах зээл хөгжихгүй байгаа нь төрийн алдаатай шийдвэртэй холбоотой. Төр бусдад хэтрхий их таалагдах гэж ажиллаж байна. Авлига хүнд сурталд автсан байна. Хөрөнгө санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа хэтэрхий удаан, хувийн хэвшлийн хурдаа гүйцэхгүй байна. Харин ч арагш нь чангааж байна.

Манай хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулагч, институционал хөрөнгө оруулагч байхгүй байна. Дээр нь даатгалын салбар нь хөгжөөгүй. Байгаа жаахан мөнгөө хөрөнгийн зах зээлд гаргах боломж муу, тэтгэврийн сангийн мөнгийг нь улстөрчид нь удирддаг, байгалийн сангууд нь байгуулагдаагүй ийм байдалтай улсад хөрөнгийн зах зээл хөгжих үү. Хадгаламжийн даатгалын корпораци, тэтгэвэр, эрүүл мэнд, даатгалын салбарын мөнгөнүүд хөрөнгийн зах зээл дээр орж ирж байж урт хугацаат хөрөнгө оруулалт хийх боломжтой болно.

Хувь хүмүүс банкинд хамгийн ихдээ лнэг жилээр мөнгөө хадгалуулна. Компаниудыг хувьцаат болсонгүй, хөрөнгийн бирж дээр хувьцаагаа гаргахгүй байна, засаглал ил тод биш муу гээд л байдаг. Нөгөө талдаа аж ахуйн нэгжүүд хувьцаагаа гаргахад хүмүүс худалдаж авахгүй бол хичнээн ил тод байх гээд яах вэ. Зах зээлийн эрэлт хэрэгцээний журмаар л асуудлууд зохицуулагдана. Гаднын хөрөнгө оруулагчдын хувьд бол биднээс айсан, үргэсэн шүү дээ.

**“Ард санхүүгийн нэгдэл” Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргахад бэлтгэж байгаа. Энэ тухай та жаахан дэлгэрүүлж мэдээлэл өгөхгүй юү?**

–Бид саяхан хөрөнгийн зах зээл дээр арилжаа хийгээд “Жинст Увс” компанийн хяналтын 84,6 хувийг худалдаж авсан. Хүмүүс ойлгохгүй байгаа. Яагаад жижиг компанийн хяналтыг багцийг авав гэж. Монголын хөрөнгийн биржэд бүртгэлтэй компанийн хяналтын хувийг хаалттай компани худалдан авснаар бирж дээр нээлттэй арилжаанд оролцох боломжтой болж байгаа юм.

“Ард санхүүгийн нэгдэл”-д 330 хувьцаа эзэмшигч бий. Хувь хүмүүс ч бий, манай томоохон компаниуд ч хувьцаа эзэмшдэг. Бид нэгдэж нийлээд үндэсний томоохон санхүүгийн корпораци больё гэж зорьсон. Санхүүгийн зах зээл дээр шинэлэг үйлчилгээг иргэдэд санал болгоё, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг, мөн бидэнд итгээд ороод ирсэн жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийн үнэ цэнийг хамгийн өндөр түвшинд байлгах зорилготой ажиллаж байна.

Бид хөрөнгийн зах зээлд гарснаар зөвхөн “Ард санхүүгийн нэгдэл”-ийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын хувьцааны эргэлтийг нэмэгдүүлэх, хөрвөх чадварыг сайжруулах гэж харахгүй байгаа. Санхүүгийн зохицуулах хороо, холбогдох байгууллагууд манайхыг бодлогоор дэмжиж ажиллахаа илэрхийлсэн. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өргөжүүлэх, идэвхжүүлэх, олон нийтэд танилцуулах үйл ажиллагаанд бид хувь нэмрээ оруулж, түлхэц болохыг хүсэж байгаа.

**–Хувьцаагаа яг хэдийд**

**гаргахад төлөвлөсөн бэ?**

–Тодорхой хугацаа хэлмээргүй байна. Сайн засаглалтай, ил тод, нээлттэй компаниудад хөрөнгө оруулалт хийсэн холдинг компаниуд хөрөнгийн бирж дээр гарахад иргэдийн сонирхол их байх болов уу. Нөгөө талдаа миний хувьд ХАС банк, Хас Лизинг зэрэг олон байгууллагыг үүсгэн байгуулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын мөнгийг аваад зүй зохистой удирдаж, амжилтад хүргэж явсан болохоор нийт Монголынхоо ард иргэдийн итгэлийг дааж, мөнгө хөрөнгийг нь өсгөж нэмэгдүүлэх, итгэл даан сайн ажиллах хүн гэсэн хүлээлт зах зээлд байгаа болов уу гэж бодож байна.

Олон иргэн манай нэгдэл рүү хандаж байгаа. Хүлээх хэрэгтэй. Юуны өмнө бид ажлаа хийх ёстой. Холбогдох байгууллагуудаас дүрэм журмын дагуу зөвшөөрлөө авна. Дараа нь хувьцаагаа гаргана. Монголын хамгийн өндөр үнэлгээтэй, хариуцлагатай, өгөөжтэй, хүлээлттэй, ил тод, нээлттэй, хувьцаат компанийг бий болгоно гэж төлөвлөж байна.

**–Шүүхээс саяхан банкны шимтгэл төлөх нь буруу гэсэн шийдвэр гаргалаа. Та ямар бодолтой байна вэ?**

–Ер нь зах зээлийг жамаар нь хөгжүүлбэл хурдтай зөв явдаг. Банкны шимтгэлийг буцаах нь хувь хүнийхээ хувьд буруу шийдвэр гэж үзэж байгаа. Хувийн хэвшлийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байхад нь очоод л шалгаад хянаад зах зээлийн зарчимд үл нийцсэн шийдвэр гаргадаг байдалдаа төр дүгнэлт хийх цаг ирсэн. Би Магнай гэж хүний популизм гэж харж байгаа. Хүмүүс цаад сөрөг нөлөөг нь харж чадахгүй байгаа л даа. Банкны шимтгэл төлөхгүй болох нь гэсэн сэтгэлийн хөөрлөөр харж баясаж болох. Холын хор уршиг нь зах зээл гэдэг зүйлийг л байхгүй болгох гээд байгаа алхмууд юм.

Манай банкууд өнөөдөр 12-13 их наяд төгрөгийн зээл гаргаад байна. Анхлан ХАС банкныг байгуулаад явж байх үетэй харьцуулахад энэ салбар хөгжсөн. Зээлийн хүүний хувьд өндөр, бага гэж маргалдаж болно. Хойд хөрштэй харьцуулаад

үз. Тус улсад манайхаас өндөр хүү үйлчилдэг.

**–Бид хэдэн том үндэсний компани дэмжиж байж хөгжинө. Том аж ахуйн нэгжүүдийг дагаад жижиг, дунд нь хөгжсөн бусад орны жишээ олон. Харин монголчуудын дунд улсын татварын ихэнхийг бүрүүлдэг компаниудаа татаж унагах сэтгэхүй яваад байдаг та юу хэлэх вэ?**

–Бид амжилт гэж ярьдаг. Бүгд л амжилттай ажиллаж, баян чинээлэг сайхан амьдрахыг хүсдэг. Тэрхүү амжилтад хүрэхийн тулд их хөдөлмөрлөх хэрэгтэй. Оюун ухаан, хүч хөдөлмөрөө илүү зарцуулж амжилтад хүрсэн хүмүүс өнөөдөр олон бий. Тийм хүмүүсийн тоо ч жилээс жилд өссөөр. Гэтэл бусад хүн тэр хүмүүсийг хараад яагаад эд нар гэнэт баяжаад дээшээ гараад явчихав гэдэг байдлаар хандаж, татан унагах, атаархах сэтгэхүйдээ дийлдэж эхэлнэ. Уг нь 100, 1000, 2000-уулаа дээш гарч байж л улс хөгжинө. Улс орныхоо хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж яваа компаниудаа төрөөс бодитой дэмжих ёстой. Ном зохиол, киногоор дамжуулан ийм компани шиг ажиллах хэрэгтэй, ийм хүмүүс шиг хөдөлмөрлөх ёстой хэмээн дэмжин урамшуулж, олон нийтийг зөв сэтгэхүйтэй болгохын оронд хулгайч, баян тарганаар нь дуудан доош татан унагах процесс явдаг. Тэгээд бүгд нэг хэвийн социализмын саарал системд орж амьдрахыг хүсээд байх шиг. Энэ бол популизмын хариу.

Хулгай дээрэм хийдэг хүмүүсийг шалгаж, ялыг нь үүрүүлдэг байгууллагууд тусдаа бий. Өнөөдөр баян болсон нь тэр хүмүүсийн буруу биш биз дээ. Тэд өөрийн хүч хөдөлмөрөөрөө л амьдарч буй хүмүүс. Харин гудамжинд өлсөж буй, бүх малаа шуургаанд хийсгэсэн хүнийг өрөвдөх сэтгэл давамгайлах талдаа. Гэтэл 160 гаруй мянган төрийн албан хаагчдыг тэжээж яваа баялаг бүтээгчид нь луйварчин, олигархиар дуудуулаад явж байгаа юм. Зүгээр суудаг, ажилгүй хүмүүсийн хүүхдүүдийг сургадаг сургууль болон эмнэлгийн цахилгаан, дулааныг нь нөгөө баян тарганаараа дуудуулдаг бизнесмэнүүд л төлнө. Татварын 99 орчим хувийг манай зуун том компани л төлдөг. Том

компаниудаа дэмжиж байж бид Монгол Улсын өрсөлдөх чадварыг бий болгоно. Үндэсний аж ахуйн нэгжүүдээ тодорхой сайн бодлогоор дэмжсэнээр үндэстэн дамнасан корпорацийг бий болгоно.

**-Улаанбаатар хотын Худалдааны танхимыг байгууллаа. Бусад төрийн бус байгууллагуудаас юугаар ялгарах танхим байх вэ?**

-Худалдааны танхим нь Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаална, тэдний дуу хоолой болж ажиллана. Төрд тэдний дуу хоолойг хүргэх юм. Нөгөө талаар популистууд дуугарч чадаж байгаа бол бид бизнесмэнүүд сөрж зогсож, ажиллах юм. Эрүүл саруул ухаанаар асуудалд ханддаг улстөрчид биднийг дэмжиж ажиллах байх.

Нийслэлд маань Монгол Улсын аж ахуйн нэгжүүдийн ихэнх нь үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж буй гадны хөрөнгө оруулалттай компаниудын оффис Улаанбаатар хотод л байрладаг. Улсын бүх салбарын гол ажлууд нийслэлд л явж байна. Хүн амын олонхи нь энэ л хотод суурьшин амьдарч байна. Тэгэхээр бизнес, эдийн засгийн өрсөлдөх чадварыг Улаанбаатар хот бий болгоно. Монгол Улсын хөгжлийн нүүр царай нийслэл маань шүү дээ. Тийм учраас хотын асуудлыг зөвхөн хотын захиргаа шийдэх ёстой гэж хаяхгүйгээр хотын хөгжлийг хамтдаа шийдье, хөгжүүлье, сайхан тохилог, эмх замбараатай хотыг хамтдаа бий болгож, хөгжүүлье гэсэн зорилготой бизнесмэнүүдийн үүсгэн байгуулсан танхим цаашид үйл ажиллагаагаа эрчимтэй идэвхтэй явуулна. Мөн ирээдүйд Ази, бүс нутагтаа Улаанбаатар хотыг санхүү, бизнесийн төв болгох алсын хараатай ажлаа уялдуулж ажиллана. Монголын томоохон 60 гаруй компанийн төлөөлөл Улаанбаатар хотын Худалдааны танхимыг үүсгэн байгуулсан. Танай “Mongolian Economy” сэтгүүл ч гэсэн тус танхимын үүсгэн байгуулагч 60 хувийн хэвшлийн байгууллагын тоонд байгаа болохоор хотын хөгжлийг хамтдаа шийдэж, санаа бодлоо хэлж танхимын ажлыг дэмжиж ажиллана гэж бодож байна. ■

## Улаанбаатар хотын худалдааны танхимын Ерөнхийлөгчөөр Ж.Од сонгогдлоо



Улаанбаатар хотод бизнес эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн үүсгэл санаачлагаар “Улаанбаатар хотын /нийслэлийн/ худалдааны танхим”-ыг нөөдөр үүсгэн байгууллаа. Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй томоохон компанийн захирлууд багагүй хугацаанд ярилцаж, хэлэлцсэний эцэст ийм танхим байгуулах шийдвэрт хүрчээ.

Танхим нь нийслэлийн эдийн засгийн хөгжлийг дэмжих, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд хотын захиргаатай хамтран ажиллах төдийгүй Улаанбаатар хотыг бүс нутгийн санхүү, бизнесийн төв болгон хөгжүүлэх алсын зорилгыг тодорхойлжээ.

Энэхүү хуралд 64 компанийн төлөөлөл оролцож, дүрэм журам, ерөнхийлөгч болон төлөөлөн удирдах зөвлөлийг сонгож, баталсан юм. Төлөөлөгчдөөс MCS, Шунхлай, Ард санхүүгийн нэгдэл, Голомт банк, Ньюком, Жигүүр гранд, Номин холдинг зэрэг компанийн төлөөлөл 15 хүний бүрэлдэхүүнтэй Удирдах зөвлөлийг баталсан бол Удирдах зөвлөлийн гишүүд MCS группын ерөнхийлөгч Ж.Одыг Улаанбаатар хотын худалдааны танхимын Ерөнхийлөгчөөр 100 хувийн саналаар сонгосон.

“Дэлхийн том хотууд аж ахуйн нэгжүүдээ нэгтгэсэн.

Худалдааны танхимтай байдаг. Хотын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буй татвар төлөгч компаниудаа бодлогоор дэмжин тэдний дуу хоолойг сонсч хамтран ажиллах журмаар шийдвэр гаргаж ажилладаг туршлага бий. Нийслэлд амьдарч ажиллаж буй хүмүүс, миний хувьд ч Улаанбаатар хотоо хүн амьдрах тухтай, мөн бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдсэн, цэвэр цэмцгэр сайхан хот байхыг хүсдэг мөрөөддөг. Тиймээс бизнес эрхлэгчдийнхээ санаачлагаар үүсгэн байгуулж буй Танхимын үндэс суурийг зөв, баттай тавихад бизнесийнхэнтэй, Нийслэлийн удирдлагуудтай нэгдэн нийлж, хамтран ажиллах болно” гэж Танхимын ерөнхийлөгч Ж.Од хэлсэн юм.

Дүрмийн дагуу Танхимын ерөнхийлөгчийг хоёр жилийн хугацаатай томилох бөгөөд хоёр удаа улиран сонгох эрхтэй. Төлөөлөн удирдах зөвлөлийг 15 гишүүнтэй байхаар зааж, өдөр тутмын ажлыг гүйцэтгэх ажлын алба байгуулах юм байна.

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Улаанбаатар хотын худалдааны танхим юугаараа ялгаатай вэ гэсэн асуудлыг олон хүн сонирхож байсан. Улаанбаатар хотын танхимын Удирдах зөвлөлийн гишүүн, Монголын хөрөнгө оруулалтын сангийн захирал Б.Батсайхан “МҮХАҮТ бол том, жижиг олон компаниудыг нэгтгэсэн үндэсний хэмжээний байгууллага. Мөн орон нутгийн салбаруудаараа дамжуулан өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг. Харин манай Танхимын хувьд нийслэлд үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн хүрээнд үйл ажиллагаа явуулна. Мөн мэргэжлийн холбоод, МҮХАҮТ-тай хамтарч ажиллах болно” гэлээ. ■

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

# Урт хугацаанд хөрөнгө оруулалт өсөн нэмэгдэх боломж

Г.МӨНХ-ЭРДЭНЭ /Хөрөнгө оруулалтын шинжээч, “Гаули” ҮЦК/

## 2015 ОНЫ ХОЁРДУГААР ХАГАСТ ШИЙДЭГДЭХ ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙНА

Оюцтолгойн ил уурхайд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ хэтэрсэн нь Монголын талын ногдол ашиг хүртэх хугацааг хойшлоход хүргэснээс улбаалан 2013 оны дунд үед далд уурхайн бүтээн байгуулалтыг Монголын талаас зогсоосон. Далд уурхайн хөрөнгө оруулалтыг хийх талаарх эцсийн саналаа “Рио Тинто”-гийн зүгээс 2014 оны арваннэгдүгээр сард Монгол Улсын Засгийн газарт тавьсан бол Монгол Улсын Засгийн газраас Оюутолгойн 34 хувиа нэмэгдэл роялти авах байдлаар солих саналыг 2015 оны хоёрдугаар сард тавьсан. “Рио Тинто”-гийн зүгээс дээрх саналыг хүлээн авах сонирхолгүй байгаагаа мэдэгдсэн. Хэрэв далд уурхайн бүтээн байгуулалт эхэлбэл 5.4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг ирэх дөрвөн жилийн хугацаанд хийх юм.

## ХЭЛЭЛЦЭЭР ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

Тавантолгойн асуудлаар МУ-ын сайд М.Энхсайханы мэдэгдэхдээ буйгаар талууд гэрээний голлох нөхцөлүүдээ тохиролцсон гэж буй. Монголын талаас анхаарч үзэх ёстой бүх асуудал багтсан аж.

Харин УИХ-ын зүгээс уг гэрээг УИХ-аар хэлэлцүүлж батлуулах шаардлагатай гэж үзэж байгаа юм.

ЭТТ ХК-ийн “Чалко” компанитай байгуулсан гэрээний хүрээнд хүлээх үүргийг хэрхэн хангах асуудлыг нухацтай хэлэлцэхгүй бол гэрээ

байгуулахад хүндрэл учирч эхлээд байна. Ингэснээр гэрээ байгуулагдах хугацаа хойшлох нөхцөл бүрдэж эхэллээ.

Хэрэв гэрээ байгуулагдвал дөрвөн тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг гурван жилийн хугацаанд хийх юм.

Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг хүчингүй болгож Хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталсан. Уг хууль нь төрийн шууд оролцоог хумиж, хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах чиглэлд ахиц гаргасан.

Газрын тосны тухай хуулийг 2014 оны долоодугаар сард шинэчлэн батлаж уламжлалт бус газрын тосны салбарт хөрөнгө оруулалт татах боломж нээгдлээ. Энэ салбарт нүүрсний давхаргын метан хийг ашиглах, шатдаг занар олборлох хүсэлтэй гадаадын компаниуд хайгуулын зөвшөөрөл хүсч, хөрөнгө оруулалт хийж эхэлжээ. Монголын нүүрсний давхаргын метан хийн таамаг нөөц 3.2 их наяд шоо метр байгаа бол шатдаг занарын таамаг нөөц 788 тэрбум тн. 2014 оны есдүгээр сарын байдлаар газрын тосны хайгуулын зургаа, нүүрсний метан хийн гурав, шатдаг занарын хоёр гэрээ зурагдсан байна.

106 лицензийг эргэлтэд эргэн оруулж нээлттэй уралдаант шалгаруулалт явуулах замаар шинэ эзэмшигчийг тогтоож байна. 2014 оны наймдугаар сарын 21-ний өдрөөс өнөөдрийг хүртэлх хугацаанд 37 талбайд дөрвөн удаагийн сонгон шалгаруулалтыг амжилттай зохион

байгууллаа. Ингэхдээ 106 тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хохиролгүй болгох үүднээс, өмнөх эзэмшигчийн зардлаар баталгаажсан тендер зарлаж байна. Хэрэв тендер өрсөлдөгчгүй явагдвал өмнөх эзэмшигчид нь тусгай зөвшөөрлийг олгож, харин өөр компани ялбал босго үнээр өмнөх эзэмшигчийн зардлыг гаргуулахаар шийджээ. Өнөөдрийн байдлаар нийт 42 талбай дээр компаниуд зардлаа баталгаажуулаад байна. Эдгээрээс 29 тусгай зөвшөөрөл өмнөх эзэмшигчдээ очсон бол зургаан талбайд гуравдагч тал ялалт байгуулжээ.

Мөн хайгуулын тусгай зөвшөөрлийг олгож эхэллээ. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 19.8 хувь буюу 31 сая га талбайд тусгай зөвшөөрөл олгохоор төлөвлөөд буй бөгөөд үүнээс 20.9 сая га талбайд өргөдлийн журмаар, 10.1 сая га талбайд сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл олгох юм байна.

## ГШХО БА ДОЛЛАРЫН ХАНШИЙН ТААМАГЛАЛ

2010 оны дунд үеэс өнөөг хүртэлх ГШХО ба долларын ханшийн корреляцийн коэффициент -0.73 байгаа нь хүчтэй хамааралтайг илэрхийлж байна. Мэдрэмжийн шинжилгээ хийж үзэхэд ГШХО нэг хувиар өсөхөд долларын ханш 0.24 хувиар буурч байна. Оюутолгой, Тавантолгойн асуудал шийдэгдэн ГШХО-ын хэмжээ нэг тэрбум ам.долларт хүрвэл 2015 оны эцэст долларын ханш 1900-гаас буух боломж бүрдэх юм.

ИНФОГРАФИК

### Гадаадын шууд хөрөнгө оруулалт өнгөрсөн онуудад

Сүүлийн хоёр жил хагасын хугацаанд 91,6 хувиар буурлаа



2013 оноос хууль эрх зүйн орчин лочтг сайжирч байгаа ч улс төрийн байдал тогтворгүй хэвээр байна, Мөн түүхий эдийн үнэ өсөхгүй байгаа нь хөрөнгө оруулалт нэмэгдэхэд хүндрэл учруулж байна.

Алт, зэс, нүүрсний үнэ өссөн	Алт, зэс, нүүрсний үнэ унасан
------------------------------	-------------------------------

Жилийн бууралт

**Өөрчлөлт**

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад

-4.60%

**2012**

-40.23%

-52.40%

**2013**

-34.44%

-80.70%

**2014**

-104.27%



2015 оны нэгдүгээр сарын статистик мэдээлэл хараахан гараагүй байна. Харин 2014 оны аравдугаар сард 121.9 сая, арваннэгдүгээр сард 148.6 сая ам.долларын хөрөнгө оруулалт тус тус гадагшилсан нь анхаарал татаж байгаа юм. Энэ жилийн хувьд жилийн эхний хагсат хөрөнгө оруулалтын хэмжээ өсөх төлөвгүй байна.



## ДУГНЭЛТ


2012 оны дунд үед 4.8 тэрбум ам.доллар хүрч байсан ГШХО хоёр жил хагасын хугацаанд 400 сая ам.долларт хүрч 91.6 хувиар уналаа. Үүнд улс төр, хууль эрх зүйн орчны тогтворгүй байдал, мега төслөөс хараат байдал, түүхий эдийн уналт зэрэг суурь хүчин зүйлс нөлөөлж байна.

2012 оны гуравдугаар улирал хүртэл гадаадын хөрөнгө оруулагчид ашгаараа дахин хөрөнгө оруулалт хийж байсан бол түүнээс хойш өнөөг хүртэл ашгаа гадагш татаж байна. Мөн 2014 оны аравдугаар сард 121.9 сая, арваннэгдүгээр сард 148.6 сая ам.долларын хөрөнгө оруулалт гадагшилсан нь анхаарал татаж байна. Эдгээр нь Монголын эдийн засаг, улс төрд итгэх итгэл суларсан байгааг илтгэх үзүүлэлт юм.

Оюутолгой, Тавантолгой төслийг урагшлуулахгүй бол 2015 онд ГШХО өсөх төлөвгүй байна. ■

## 2015 оны хөрөнгө оруулалтын таамаглал

Хөрөнгө оруулалт	Хэмжээ	Хугацаа жилээр	Эхлэх хугацаа	2015 онд хийгдэх боломжтой
Оюу толгой	5.40	4.00	2015 оны хоёрдугаар хагаст	0.3-0.7 тэрбум
Таван толгой	4.00	3.00	2015 оны нэгдүгээр хагаст	0.1-0.3 тэрбум
106 лиценз	1.00	1.00	2015	0.1 тэрбум
Уламжлал бус газрын тос	Одоогоор тодорхойлох боломжгүй. Гэхдээ их дүнтэй байх боломжтой	-	2015	Одоогоор тодорхойгүй
Хайгуулын лиценз	Одоогоор тодорхойлох боломжгүй.	-	2015	Одоогоор тодорхойгүй
Өмнөх жилүүдийн өгөгдөлд тулгуурласан 2015 оны таамаглал				0.5 тэрбум
Дээрх төслүүдийн хөрөнгө оруулалт				0.5-1.1 тэрбум
<b>НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТААМАГЛАЛ</b>				<b>1-1.6 тэрбум</b>



## АСЕМ МОНГОЛ

# Алтан БОЛОМЖ

2016 он Монгол Улсын хувьд чухал жил. Учир нь дэлхийн 51 орны төр, засгийн тэргүүнүүд манайд цуглана бас чуулна. Өнгөрсөн онд Италийн Милан хотноо өрнөсөн АСЕМ-ийн уулзалтын шийдвэрийн дагуу дараагийн буюу 2016 оны уулзалтыг манай улс даргалахаар болсон билээ. Ийнхүү уулзалт ирэх оны долоодугаар сард Улаанбаатар хотноо болох гэж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу АСЕМ-ийн уулзалтыг зохион байгуулах Үндэсний зөвлөл байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд одоогоор 5000 гаруй зочин, төлөөлөгч оролцох төлөв гарчээ.

Үндэсний зөвлөлийн даргаар Ерөнхий сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, дэд даргаар Гадаад хэргийн сайд томилогдон ажиллаж байна. Харин зөвлөлийн гишүүдээр Сангийн сайд, Зам, тээврийн сайд,

Монгол Улсын сайд, Засгийн газрын ХЭГ-ын дарга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, гадаад бодлогын зөвлөх болон Олон нийтийн харилцааны бодлогын зөвлөх, УИХ-ын даргын ахлах зөвлөх, Ерөнхий сайдын ахлах зөвлөх болон олон нийттэй харилцах асуудал эрхэлсэн зөвлөх мөн ҮАБЗ-ийн ажлын албаны дарга нар ажиллаж байна. Харин нарийн бичгийн даргаар ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга томилогджээ.

Үндэсний зөвлөлийн анхны хуралдаан энэ оны нэгдүгээр сард болж, дээд түвшний уулзалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг хэлэлцэн, ажлын хэсгүүдийг байгуулжээ. Мөн ээлжит хуралдаан саяхан болж, АСЕМ-ийн уулзалтаас “Даргын мэдэгдэл” болон “Улаанбаатарын тунхаглал” гэх хоёр баримт бичиг гаргахаар төлөвлөж байгаа талаар Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн ярих. Даргын мэдэгдэлд өнгөрсөн 20 жилд гишүүн орнуудын хооронд харилцаа, хамтын ажиллагаанд гаргасан амжилт болон алдаа дутагдлаа дүгнэх, Улаанбаатарын тунхаглалд

ирээдүйд чиглэсэн төр, засгийн тэргүүнүүдийн үзэл баримтлал, чиг хандлагыг илүүтэйгээр тусгахаар төлөвлөж байгаа аж. Манай улсын хувьд тус уулзалтыг амжилттай зохион байгуулснаар олон улсад нэр хүнд өсөх, улмаар гадаадын хөрөнгө оруулалт, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх таатай боломж гэж үзэж байна. Нөгөө талаас 2016 онд АСЕМ-ийн дээд түвшний уулзалтын 20 жилийн ой тохиож буйгаараа онцлог учир зохион байгуулагч орны хувьд их хариуцлага ногдож байгаа. Үндэсний зөвлөлийнхөн энэ сардаа дахин хуралдах бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд АСЕМ-ийн уулзалтын логог зохион бүтээх уралдаан зарлаад байна.

“Asia-Europe Meeting” /ASEM/ буюу Ази-Европын уулзалт нь хоёр тивийн бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, тулгарч буй сорилтуудыг даван туулах, хамтын шийдвэр гаргах олон талт яриа хэлэлцээний чухал суваг юм.

АСЕМ нь Европын холбооны гишүүн 28 орон, Европын хоёр орон, Азийн 21 орон, АСЕМ-ийн Нарийн бичгийн даргын газар зэрэг нийт 53 гишүүнтэй байгууллага юм. ■



Дөрөвдүгээр цахилгаан станц Төрийн Гэрэгэ шагналын эзэн боллоо

## ТӨРИЙН ГЭРЭГЭ

# Хөгжлийн түүчээ - ДЦС-4

## Ц.ЭЛБЭГСАЙХАН

Улс орныхоо өрсөлдөх чадварын нэрийн хуудас болж чадсан томоохон бүтээн байгуулалтад жил бүрийн билгийн тооллоор он солигдохын өмнөхөн Монгол Улсын Ерөнхийлөгч “Төрийн Гэрэгэ” шагнал олгодог билээ.

“Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл” дээрх шалгуурт бүрэн тэнцэж, 2014 оны “Төрийн Гэрэгэ”-гийн эзэн болсон юм. Энэхүү шагналд нэр дэвшсэн төслүүд, бүтээн байгуулалтууд улс орны хөгжил дэвшилд ямар үүрэг гүйцэтгэсэн, ард иргэдийн ахуй амьдралд хэрхэн нөлөөлж буйг тодорхой судалгаа баримтаар гаргаж ирсэн байх ёстой шалгуур тавьдаг. Өнгөрсөн жилийн энэхүү шагналд 40 гаруй томоохон бүтээн байгуулалт нэр дэвшсэн бөгөөд хамгийн шилдэг гурвын нэг нь Дөрөвдүгээр станцын

өргөтгөлийн төсөл юм. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “ДЦС-4” ТӨХК-д “Төрийн гэрэгэ” шагнал гардуулах үеэрээ “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 123 МВт-аар өргөтгөх төсөл цахилгаан, дулааны өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангахад чухал үүрэгтэй төдийгүй үндэсний бүтээн байгуулалт, үйлдвэрлэл хөгжихөд үр ашгаа өгөх суурь бүтээн байгуулалт болсон.” хэмээн төслийн ач холбогдлыг тодотгосон билээ.

Дээрх төслийн хүрээнд цагт 188 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэх, цахилгаан эрчим хүчний 123 МВт хүчин чадалтай турбин хөдөлгүүрийг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцад нэмж суурилуулснаар шинээр 250 мянган айл өрхийг цахилгаанаар, 15 мянган айл өрхийг дулаанаар хангах боломжтой болсон. Энэ бол Монгол

Улсад сүүлийн 30 жилд хийгээгүй том бүтээн байгуулалт ажээ.

Өнгөрсөн хугацаанд манай улс эрчим хүчний хүчин чадлыг өсгөж ирсэн ч ийм хэмжээгээр нэмэгдүүлж байгаа нь анхных юм. Тус станц манай улсын хамгийн өндөр хүчин чадалтай цахилгаан үүсгүүрүүдтэй, хамгийн том цахилгаан, дулаан үйлдвэрлэгч. 80 МВт чадалтай гурав, 100 МВт-ын гурван турбинтай. Тэгвэл станцын өргөтгөлийн хүрээнд шинээр суурилуулсан нэг турбин нь дангаараа жилд 500 сая КВт цахилгаан үйлдвэрлэх хүчин чадалтай юм байна. Бахархам амжилт. Нэг хэсэгтээ л толгойны өвчнөөсөө салах нөхцөл бүрдсэнийг мэргэжилтнүүд хэлж байна. Тухайлбал, “ДЦС-4”-ийн өргөтгөлийн чадал тэнхээгээр бид 2017 он хүртэл санаа зоволтгүй боллоо” хэмээн уг төслийн удирдагч Д.Батчулуун ярьсан юм.

Эрчим хүчний хэрэглээ жилээс жилд өссөөр байгааг бид мэднэ. 2010-2014 онд нийтдээ 35 мянга орчим айлын орон сууц ашиглалтад орж, улсын хэмжээний томоохон бүтээн байгуулалтууд идэвхжсэнээр эрчим хүчний хэрэглээ 8-10 хувь нэмэгдэж огцом өсөлт бий болгожээ. Ялангуяа, Төвийн бүсийн эрчим хүч ачааллаа дийлэхгүйд хүрч байгаад эрчим хүчний салбарынхан санаа зовж буйгаа байнга л ярих болсон. Тухайлбал, 2011 оны сүүлээр 582 МВт-ын нийлбэр ачаалал авч байсан Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц 2013 оны нэгдүгээр сард 602 МВт-ын ачаалал авчээ. Өөрөөр хэлбэл, тус станц суурилагдсан хүчин чадлаа 20 гаруй МВт-аар хэтрүүлсэн гэсэн үг бөгөөд энэ нь Дулааны хоёрдугаар цахилгаан станцын суурилагдсан хүчин чадалтай тэнцэж байгаа юм. Байдал энэ хэвээрээ цааш үргэлжилбэл эрчимтэй нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг хангаж чадахгүйд хүрч, цахилгааны хязгаарлалт хийх хэмжээнд очих байв. Тиймээс холбогдох байгууллагуудаас энэ асуудлыг ойрын хугацаанд шийдэх гарц хайж, судалж үзсэний үндсэн дээр Гурав болон Лөрөвдүгээр цахилгаан станцуудад хүчин чадлын өргөтгөл хийх шийдвэрт хүрчээ.

Засгийн газраас ч Дөрөвдүгээр станцын хүчин чадлыг 100 МВт-аар өргөтгөх тогтоолыг 2012 оны аравдугаар сард гаргаж, бондын хөрөнгөнөөс 70 сая ам.долларын санхүүжилт хийхээр шийдвэрлэсэн байна. Урьдчилсан ТЭЗҮ-ээр 75 сая ам.доллар шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан ч засаг шаардагдах хөрөнгийг цаг алдалгүй шийдсэн нь сайшаалтай.

Өргөтгөлд шаардлагатай хүчин чадал бүхий турбиныг Уралын турбины үйлдвэрт захиалж хийлгэжээ. Харин угсралт, гүйцэтгэлийг ОХУ-ын Эрчим хүчний барилга байгууламжийн “СОЮЗ” корпораци хариуцаж, хойд

хөрш болон Украин улсын 150, дотоодын 10-аад компанийн 160 гаруй ажилтан гар бие оролцсон байна.

#### Яагаад “ДЦС-4” гэж

Нэгдүгээрт, тус станцад ийм боломж нь байсан. Хоёрдугаарт, эдийн засгийн өгөөж их. Бэлэн бааз сууриа түшиглэж, станцын хүчин чадлыг өргөтгөснөөр нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх өртөг багасч, алдагдал буурсан ач холбогдолтой. Тухайлбал, өнгөрсөн онд тус компани нэг төгрөгийн орлого тутамд 20 мөнгөний алдагдал хүлээж байв. Төсөл хэрэгжсэнээр дээрх тоо 3.3 дахин буурч зургаан мөнгө болжээ. Харин компани хөрөнгө оруулалтын өртгөө 5-8 жилд бүрэн нөхнө гэж тооцжээ.

Дөрөвдүгээр станц нь төвийн бүсийн эрчим хүчний 70 хувийг хангадаг. Улсын хэмжээнд энэ оны нэгдүгээр сарын байдлаар нийт 498.8 сая КВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэснээс 321.8 саяыг нь тус станц дангаараа үйлдвэрлэжээ. Дөрөвдүгээр станцын өргөтгөлөөс гадна “ДЦС-3” ТӨХК-д 50 МВт-ын өргөтгөлийн ажлыг мөн хийснээр манай цахилгаан, эрчим хүчний суурилагдсан нийт хүчин чадал мянган МВт-д хүрсэн бол дөрөвдүгээр цахилгаан станцынх 700 МВт болжээ.

Энэхүү төсөл маш хямд зардлаар хэрэгжсэн байна. Бүтээн байгуулалтын нийт өртгийг цахилгаан эрчим хүчний өргөтгөсөн хүчин чадалд хуваахад нэг МВт-д 570 мянган ам.доллар зарцуулжээ. Энэ нь олон улсын жишгээс даруй дөрөв дахин бага тоо аж. Ийм үр дүнд хүрэхэд гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ чухал нөлөө үзүүлжээ. ОХУ-ын “СОЮЗ”-ын мэргэжилтнүүд 2012 оны арванхоёрдугаар сард газар дээр нь ирж байдалтай танилцаад төлөвлөснөөс гурав дахин их үнэ хэлсэн байна. Гүйцэтгэгч талтай бүтэн зургаан сар хэлэлцээр хийсний эцэст хүссэн нөхцлөөрөө байгаа хөрөнгөдөө багтаан турбиныг суурилуулж ашиглалтад оруулахаар



тохиролцжээ. Ийнхүү орос, украин, монголын мэргэжилтнүүдийн уйгагүй хөдөлмөр зүтгэлээр угсралт, суурилуулалтын ажил 2014 оны арванхоёрдугаар сард бүрэн дууссанаар туршилт, тохируулгын горимд шилжсэн байна. Төслийг үндсэндээ хоёр жилд хэрэгжүүлсэн бөгөөд хамгийн гол ажлаа зургаан сарын дотор нугалсан байна. Харин ийм хэмжээний бүтээн байгуулалтыг хийхэд олон улсад дунджаар дөрвөн жил шаардагддаг ажээ. Төслийн удирдагч Д.Багчулуунаас энэ талаар тодруулсан юм.

**-Энэ том хэмжээний бүтээн байгуулалт, нүсэр ажлыг амжуулахад саад, бэрхшээл байсан л байх?**

-Хүндрэл бэрхшээл байлгүй яах вэ. Тухайлбал, маш өндөр ачаалалтай ажилладаг турбинуудын дунд угсралт хийх нь өөрөө их хүнд ажил. Жишээ нь, генераторын статорыг ажиллаж буй гурван турбин дээгүүр зөөж байршуулах хэрэгтэй байлаа. Үүний тулд 55 тоннын даацтай хоёр кранаа тус бүрийг 70 тонн даацтай болгож нэмэх шаардлагатай болсон. Гүйцэтгэгч нь өмнө нь олон том төсөл, бүтээн байгуулалт дээр ажилласан туршлагатай баг учраас алхам тутамдаа хяналт тавьж, шалгаж байсан болохоор ажлын дахин гүйцэтгэл их цөөн гарсан. Төслийг богино хугацаанд хэрэгжүүлж дуусгасан гол хүчин зүйл нь энэ.

**-Ийм хүнд, хэцүү ажлыг дэлхийн жишгээс хоёр дахин богино хугацаанд хийж дуусгажээ. Аюулгүй гэдгийг нь яаж батлах вэ?**

-Шинэ турбиныг гуравдугаар сарын 1-ний 23:34 цагт сүлжээнд залгаж, эрчим хүч түгээж эхэлсэн. Эхэндээ хагас ачааллуулж байгаад гуравдугаар сарын 6-наас цагт 125-126 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлээд тасралтгүй 76 цаг болж байна. Шинэ турбины эрчим хүч гаргах зохистой хэмжээ нь 123 МВт, дээд хүчин чадал нь 130 МВт. Турбинд бүрэн ачаалал өгөөд 72 цаг ямар нэгэн асуудалгүйгээр тасралтгүй ажиллавал цаашдаа найдвартай аюулгүй гэж үздэг гэв.

Улс орны хүнд цагт Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц



“ДЦС-4” шинээр суурилуулсан турбин

хөгжлийг урагшлуулахаар зүтгэж байсан үед олон. Хамгийн хүнд нийгмийн шилжилтийн бараан үе гэгддэг 1990-ээд онд ч тус станц хаалгаа бүр мөсөн барьчихгүйн тулд ажилтнууд нь сэтгэл зүрхээрээ хичээн зүтгэж байсан юм. Цахилгаан, дулаан тасарч, харанхуй дунд лаа барин өнгөрөөсөн өдрүүд байсныг бид мэдэх. Төрийн зөв бодлого шийдвэр, япончуудын зээлийн хөрөнгөөр станц хөл дээрээ босч ирж, Монгол Улсын хөгжлийн шинэ эрин үеийг түүчээлэн урагшилсан түүхтэй.

Тэгвэл өнөөдөр улс орны хөгжлийн бас нэгэн шинэ эрин эхэлж байна. Цахилгаан эрчим хүчийг ихээр шаардсан орон сууцны хороолол, уул уурхайн томоохон төсөл хөтөлбөр,

бүтээн байгуулалтууд хэрэгжиж байна. Жилээс жилд өсөн нэмэгдэх тэрхүү цахилгаан, дулааны хэрэгцээг хангах шаардлага гараад байсан үед Дөрөвдүгээр станц хүчин чадлаа нэмж, хурдтай хөгжлийг хэдэн жилдээ хангах хэмжээний нөөцтэй болж, улсаа, ард иргэдээ цахилгаан, дулааны хязгаарлалтаас аварлаа гэж хэлэх бүрэн үндэстэй.

Улсын хөгжлийн цаашдын ирээдүйг тодорхойлох Дулааны тавдугаар станцыг барьж, ашиглалтад оруулах хүртэл Дөрөвдүгээр станц ачааллыг авч, амьдралыг хэвийн үргэлжүүлэх, улс орныг, айл өрхийг гэрэл гэгээтэй байлгах үүргээ амжилттай гүйцэтгэсээр байгаа учраас тус станц Төрийн Гэрэшагнал хүртсэн билээ. ■

## ИНФЛЯЦИ

## Оновчтой бодлогын үр дүн



## Ц.САЙХАНАА

Инфляци хоёрдугаар сард 9.3 хувьд хүрч буурчээ (нэгдүгээр сард 9.8 хувь байв). Оны эхлэлд инфляци ийнхүү нэг оронтой тооруу орж чадсан нь олон жилийн хүлээлт биелсэн хэрэг боллоо. Жилийн яг энэ үед инфляци өсөх хандлагатай байдаг бөгөөд үргэлж хоёр оронтой гарч байв. Ялангуяа долоон сарын өмнө 14.9 хувьд хүрчихээд байсан инфляци ингэж хурдтай буурна гэж олон хүн таамаглаагүй биз ээ.

Тиймээс энэ чихэнд чимэгтэй мэдээг зөв зүйтэй алхам, арга зам сонгож хэрэгжүүлсний үр дүн гэж үзэж болох. Инфляцийг бууруулахын төлөө Засгийн газар, Монголбанк олон ажил хийж, олон хэлбэрийн арга зам хэрэгжүүлснээс шийдвэрлэх нөлөө үзүүлсэн нь мэдээж Үнэ тогтворжуулах хөтөлбөр. “Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ

тогтворжуулах хөтөлбөр” хэрэгжсэн хугацаандаа үнэхээр зорилгоо биелүүлж хэрэглээний сагсанд жин дардаг гурил, гурилан бүтээгдэхүүн, мах, бүхий л төрлийн барааны үнийн өсөлтийн гол шалтгаан болж ирсэн шатахууны үнийг зах зээлийн савалгаанаас хамгаалж чадсан.

Төвбанкнаас хөтөлбөрийг дунд хугацаанд хэрэгжүүлж, өнгөрсөн хоёрдугаар сараас Засгийн газарт шилжүүлээд байна. Харин хөтөлбөрийг үргэлжлэн хэрэгжээсэй гэсэн хүлээлт олон хүнд байсан. Эдийн засагт ямар ч бодлого богино, дунд, урт хугацаанд үр дүнгээ үзүүлдэг. Үнэ тогтворжуулах хөтөлбөр нь дээрхийг оновчтой тодорхойлж, зөв арга замаар хэрэгжүүлж зорилгодоо хүрч чадсан бодлого байлаа гэдгийг эдийн засагчид онцлон хэлж байгаа юм.

Хөтөлбөрийн зорилго нийлүүлэлтийн гаралтай инфляцийг бууруулах, дунд хугацаанд бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх, эдийн засгийг тогтворжуулах явдал байв. Үр дүнд нь 179 мянган ажлын байр хадгалж чаджээ. Эдийн засгийн тогтвор бий болсны нэг нотолгоо нь ипотекийн зээл. Найман хувийн хүүтэй орон сууцны зээл жилээс жилд өргөжиж байгаа нь эргээд ажлын байруудаа хадгалж үлдсэнтэй холбоотой.

Инфляци ийнхүү нэг оронтой тоонд хүрч буурахад чухал нөлөө үзүүлсэн нь өргөн хэрэглээний барааны үнэ юм. Инфляцийн задаргааг бүлгээр нь авч үзвэл хүнсний бараа, ундаа усны үнэ өмнөх сараас 38 хувиар буурсан байна. Харин цэвэр инфляцийг

Согтууруулах ундаа, тамхи 2.1 хувь, Хувцас бөс бараа 7.1 хувь, Гэр ахуйн тавилга 3.7 хувь, Амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ 1.4 хувь, ус цахилгаан, түлшний үнийн хоёр дахин нэмэгдэл бүрдүүлж байна. 2010-2012 онд хөтөлбөрт хамрагдсан бараа, үйлчилгээний хөлс инфляцийн 23.7 хувийг бүрдүүлдэг байсан нь өөрчлөгджээ.

Үнэ тогтворжуулах хөтөлбөр эдийн засагт бүхэлд нь эерэг нөлөө үзүүлсэн талаар эдийн засагчид дараах тайлбарыг хэлж байгаа юм.

### ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ СЭРГЭХЭД ХӨТӨЛБӨР НЭМЭР БОЛЛОО

**Ц.Баярсайхан /УИХ-ын гишүүн, Барилга хот байгуулалтын сайд асан/:**

-2013, 2014 оны хувьд Монголбанкны явуулсан үйл ажил-



лагаа бүхэлдээ эдийн засгийг эрүүлжүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, төлбөрийн тэнцлийн хямралыг зөөллөх, макро эдийн засгийн зорилтуудыг хангаж тогтворжуулахад сайн нөлөө үзүүлээ гэж би ойлгож байгаа. Ийм зүйлийг хийж чадаагүй бол үнэхээр бид эдийн засгийн өсөлтийн тухай ярихад ч хүнд байх байсан. 2013 онд эдийн засаг 11.7 хувиар өслөө. Энэ өсөлтийн том жин буюу 8-9 хувийг Монголбанкнаас явуулсан мөнгөний бодлого хангасан гэсэн дүгнэлт гарч байсан.

Үүнтэй би санал нэг байна. Зөвхөн барилгын салбарт гэхэд бид 30, 40-өөд бүтээгдэхүүнийг гаднаас авах шаардлагагүй боллоо. 2015 оноос эхлээд цементийг гаднаас импортлох шаардлагагүй болж, 2016 оноос эхлээд бид цементийг экспортолох тухай ярих чадалтай болж

байна. Арматурыг бол 2015 он гэхэд ер нь гаднаас авах шаардлагагүй болж байна. Энэ мэтчилэнгээр дотоодын үйлдвэрлэл сэргэхэд үнэ тогтворжуулах хөтөлбөрүүд нэмэр болсон.

Ер нь үүнийг танил талтай компанидаа ч өгдөг юм биш, арилжааны банкинд зээлийнхээ баталгаа гаргаж чадсан компани нь банкнаас зээлж авч байгаа юм. Тэр талаараа бүх аж ахуйн нэгжүүдэд хүрч чадаагүй байх. Гэхдээ дотоодын үйлдвэрлэлийг дэмжих чиглэлийн гол үйлдвэрлэгч нарт үр дүнгээ өгсөн арга хэмжээ боллоо гэж харж байна. Одоо бид яг энэ суурин дээрээсээ цаашаа яах вэ гэдгийг их зөв тодорхойлох шаардлагатай байна.

### БОГИНО ХУГАЦААНД ХЭРЭГЖВЭЛ ИЛҮҮ ҮР ДҮНТЭЙ БАЙДАГ



**Б.Лхагважав /МУХАУТ-ын Ерөнхийлөгч, эдийн засагч/:**

-Инфляцийг онилсон хөтөлбөрийг Монголбанкнаас хэрэгжүүлсэн нь Үнэ тогтворжуулах хөтөлбөр гэж харж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд таван төрлийн бараа бүтээгдэхүүний үнийг барьсан.

Энэ хөтөлбөр богино хугацаанд хэрэгжвэл илүү үр дүнтэй байдаг. Түүнээс биш, урт хугацаанд хэрэгжвэл үр дүн гэхээс илүү чөлөөт зах зээлийн өрсөлдөөнийг хааж байгаа хэрэг болно.

Адилхан бараа үйлчилгээг зах зээлд борлуулдаг аж ахуйн нэгжүүдийн үнэд нөлөөлж, нэг хэсэгт нь боломж удаан хугацаагаар олгох нь буруу л даа. Манайд энийг хянадаг тогтолцоо алга.

ШӨХТГ-аас уг нь энд хяналт тавих ёстой. Татаасын бодлого түр зуур хэрэгжвэл үр дүн гардаг. Тэрнээс

биш татвар төлөгчдийн мөнгийг нэг хэсэг нь авчихаад хөтөлбөрт хамрагдаад байж болохгүй.

### ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖЭЭГҮЙ БОЛ ИНФЛЯЦИ 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУВЬД ХҮРЭХ БАЙЛАА



**Ж.Дэлгэрсайхан /СЭЗДС-ийн Санхүү удирдлагын тэнхимийн зөвлөх багш, эдийн засагч/:**

-Төвбанкнаас хэрэгжүүлсэн Үнэ тогтворжуулах хөтөлбөрүүд тодорхой хэмжээгээр зорилгодоо хүрсэн. Жишээ нь, Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах болон нефтийн бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр нь 2013, 2014 онд эдийн засагт гарч болзошгүй сөрөг үзэгдэл болон инфляцийн өсөлтийг сааруулж, түүнээс улбаалан иргэдэд ялангуяа бага дунд орлоготой иргэдийн амьжиргаанд нөлөөлж болох дарамтыг багасгасан.

Ингэснээр эдийн засагт үүсч болзошгүй байсан, иргэдийн худалдан авах чадварын доройтлоос сэргийлж, эдийн засгийн хүндрэлийг тодорхой хэмжээгээр нимгэлж чадсан. Эдгээр гол хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээгүй бол 2013, 2014 оны инфляцийн төвшин хэдийгээр хоёр оронтой тоонд хүрсэн ч түүнээс өндөр төвшин болох 15 ба түүнээс дээш хувьтай болох байсан.

Хөтөлбөрийн нөлөөгөөр 2013 онд инфляци нэг оронтой тоонд тодорхой хугацаанд байж чадсан. Мөн одоогийн инфляци нэг оронтой тоонд байгаа нь эдгээр хөтөлбөртэй тодорхой хэмжээгээр холбоотой бөгөөд үүнийг инфляцийн бүтэц дэх нийлүүлэлтийн гаралтай нөлөөлөл багассанаар тайлбарлаж болно. ■

## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

# “ITB Berlin” үзэсгэлэнд оролцсон хувийн ХЭВШЛИЙНХЭН ИНГЭЖ ХЭЛЖ байна

## Б.ЭНХЦЭЦЭГ

“International Tourism Boerse-2015” (Герман дуудлага нь И Тэ Бэ) олон улсын аялал жуулчлалын хамгийн том үзэсгэлэн энэ жил Монголоор овоглосон. Манай улсын аялал жуулчлалын салбарын 300 орчим зочин төлөөлөгч улсаа мөн байгууллагаа сурталчлахаар тус хотод цуглалаа. Мөн Европын улсуудад амьдардаг монголчууд И Тэ Бэ үзэсгэлэнд албан ёсны түнш орноор оролцож буй Монгол орныхоо оролцоог сонирхохоор олноороо ирсэн. Тиймээс ч 49 дэх удаагаа болж буй И Тэ Бэ олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн захирал Кристиан Гёке “Берлин хот өнөөдөр нүүдэлчдийн нийслэл болоод байна” хэмээн хэлсэн юм. И Тэ Бэ-д 186 орны 10.096 байгууллага өөрсдийгөө сурталчлахаар мөн шинэ, хуучин түншүүдтэйгээ уулзах гэж ирлээ. Тус үзэсгэлэнд бизнесийн түншүүдтэй уулзаж, хамтарч ажиллахаар оролцсон манай аяллын компаниудын хувьд өмнөх жилүүдийг бодвол энэ удаад ачаалал өндөтэй ажилласан гэдгээ хэлж байлаа. Монголоос нийт 16 аяллын компани оролцсон. Тэд энэ жилийн И Тэ Бэ үзэсгэлэнд хэрхэн оролцсон болоод албан ёсны түнш орны байр сууриар оролцоход ямар өөрчлөлтүүд мэдрэгдсэн талаарх сэтгэгдлээ манай сэтгүүлтэй хуваалцсан юм.

## Б. Жавхаа /“Женко Тур Бюро” компанийн ерөнхий менежер/:

Нийтдээ таван жил И Тэ Бэ үзэсгэлэнд оролцож байна. Манайх жилдээ дунджаар 14 мянга гаруй аялагч авдаг. Өнгөрсөн онуудтай харьцуулахад оролцогч компаниуд, төр болон төрийн бус байгууллагуудын идэвх зүтгэл хүчтэй байлаа. Мөн сурталчилгааны талбайн өнгө төрх, засал, тоглолт, үзүүлбэрүүд их сайн байна. Ази, тэр дундаа Монголын сурталчилгааны талбайг зорих хүмүүс өмнөх



Фотог Б.Баярсайхан

жилүүдэд нэлээд бага байдаг байсан. Ер нь уулзах цаг товлосон, зорилтот түншүүдтэйгээ л голдуу И Тэ Бэ дээр ирж уулздаг байсан бол энэ жил мэдээлэл сайн хүрсэний хүчинд аялал жуулчлалын салбарынхан болон аялагчид маш олноороо бидэнд хандаж байна. Бидэнтэй цаг тохирч уулзая гээгүй ч, сонирхож ирж буй хүмүүсийн хувьд Монголд очвол юу үзэж болох талаар илүүтэй асууж, дэлгэрэнгүй мэдээлэл авч байлаа. Бидэнтэй уулзсан үзэсгэлэнд оролцогчид ихэвчлэн гурван долоо хоногын аяллыг сонирхож байна. Манай компани нийт 50 гаруй уулзалт хийхээр товлосон ч Монголын сурталчилгааны талбай ачаалал ихтэй байсан учир 30 уулзалтыг л хийлээ. Түүнээс таван компанигаар нь эцсийн байдлаар ажиллахаар тогтсон бол бусадтай нь хэлэлцээрийн түвшинд уулзлаа. Энэ удаагийн И Тэ Бэ-д оролцсон эрчээ алдахгүй цааш үргэлжлүүлж, гаднын улсуудад Монголын талаар мэдээлэл

сурталчилгааг улиралдаа нэг хийж, Монголыг олон улсад сануулаад байх хэрэгтэй. Тухайлбал, Германд ирэх хоёр жил “Mongolia, Nomadic by Nature” гэсэн имиджээ бариад, сурталчилгаагаа үргэлжлүүлэх хэрэгтэй.

## М. Навчаа /“Цолмон Травел” компанийн захирал/:

И Тэ Бэ олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд би хувьдаа Монгол Улсаас хамгийн олон удаа буюу 25 дахь жилдээ, “Цолмон трэвел” компанийн хувиар 22 жил оролцож байна. Дэлхийд аялал жуулчлалын олон үзэсгэлэн болдог. Түүнээс хамгийн том, мэргэжлийн гэдгээрээ И Тэ Бэ чухал ач холбогдолтой. Бид бүх түнштэйгээ И Тэ Бэ дээр ирж уулзаж туршлага солилцож, цаашдын хамтын ажиллагаагаа ярьдаг. И Тэ Бэ дээр 20 гаруй жил уулзаж буй гаднын түнш ч бидэнд байна. Гаднын аяллын компаниуд эхний хэдэн жилдээ тандаж байгаад жил

бүр И Тэ Бэ-д оролцоод байхаар тогтвортой компани гэж үзэж, хамтарч ажиллахыг санал болгодог. Компаниуд бидний хувьд жил бүр шинэ түншүүдтэй холбоо тогтоох, хуучинтайгаа харилцаагаа бататгах, тодотгох нь гол ач холбогдол юм. Хэдий энэ жил Монгол түнш орны байр сууриар оролцсон үр дүн энэ жил бага мэдрэгдэж болох ч, ирэх жил илүү сайн мэдрэгдэнэ. Түүний дараагийн жилээс бүр сайн гарна. Бид энэ удаа хамгийн багадаа 5-6 жил хамтарч ажилласан 17 компанитай уулзлаа. Мөн сүүлийн 2-3 жил биднийг тандаж байсан 3-4 компани энэ жил болон ирэх жилүүдээс аяллын хөтөлбөр зохиож аялагчид явуулахаар тохирч гэрээ хийлээ. Энэ бол бидний жил бүр тогтвортой оролцож, итгэл даахаа илтгэж байсны үр дүн, том амжилт. Монголыг шинээр сонирхон, бидэнтэй уулзаж, мэдээлэл аваад явсан компани цөөнгүй байна. Аяллын компаниуд нэлээд хэдэн жил зах зээлийн судалгаа хийж итгэлтэй болсон цагтаа аялал явуулж эхэлдэг. Тиймээс тэднийг ирэх жилээс бидэнтэй хамтарч аялал зохион байгуулаад эхэлнэ гэж хэлж чадахгүй.

#### **Д.Уянга /“Нью Жуулчин” компанийн борлуулалтын менежер/:**

Манай компани 12 дахь жилдээ оролцож байна. И Тэ Бэ үзэсгэлэнд энэ жил түнш орноор оролцсоноор үзэсгэлэнд оролцогч болон үзэж буй хүмүүсийн Монголыг гэсэн идэвх өмнөх жилүүдтэй харьцуулахад нэлээд өндөр байлаа. Бид нийт 100 гаруй гаднын компанитай хамтарч ажиллаж үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ жилийн хувьд нийт 100 орчим шинэ түнштэй уулзаж, ярилцлаа. Гаднын нэг компанитай хамтарч ажиллахаар эцсийн байдлаар тохирлоо. Зарим зах зээл, тэр дундаа Оросын аялал жуулчлалын зах зээл уналттай байгаа учир Орос, Хятад, Монголыг холбосон аялал хийх хүмүүсийн сонирхол буурч, Монголоор тойрон аялал хийх хүсэлтэй жуулчдын тоо нэлээд өсөх хандлагатай байна. Жилийн жилд И Тэ Бэ-д түнш орноор оролцож буй орныг олон нийт нэлээд сонирхож байдаг. Тиймээс Монголыг энэ удаад илүү сайн мэддэг болж байгаа нь

мэдрэгдэж байна. Илүү идэвхтэй аялал болох каяак, явган аялал, мотоцикльтой аялал зэргийг түлхүү сонирхож байна. Жил бүр оролцдог шигээ энэ удаад ч мөн тэгж хандвал түнш орноор оролцсоны үр дүн гарахгүй. Төр, хувийн хэвшил аль аль нь уулзсан тэрхүү уулзалтууд, хийсэн ажлаа лавшруулж, араас нь явж ажил хэрэг болгоход идэвх зүтгэл гаргах хэрэгтэй.

#### **Г.Болор-Эрдэнэ /“Жуулчин” компанийн Герман зах зээл хариуцсан менежер/:**

Манай компани 22 дахь жилдээ оролцож байна. Бид жилдээ 8-10 мянга орчим жуулчин авдаг. Герман хэлтэй орнуудаас ирж буй жуулчид нийт аялагчдын 30-40 хувийг эзэлдэг. Энэ жилийн хувьд сурталчилгааны талбайгаасаа эхлээд бүх зүйл өвөрмөц, үнэхээр ач холбогдол өгч байна гэдэг нь мэдрэгдэж байсан. Биднийг зорин ирж буй хүмүүсийн тоо их байлаа. Тухайлбал, хэдэн жилийн өмнө Австри, Швейцарьт очиж, компаниудтай уулзаж байхад төдийлэн нааштай хандахгүй байсан атлаа энэ жил өөрсдөө бидэн дээр ирж уулзаад гэрээний түвшинд ярилцаж буй нь Монгол Улс И Тэ Бэ-д хэр өргөн хүрээтэй оролцож байгаагийн илрэл юм. Бид И Тэ Бэ үзэсгэлэнгийн үеэр нийт 58 компани, харилцагчидтайгаа уулзсан. Үүний 21 нь хуучин харилцагч, 37 шинэ компани байна. Манай сурталчилгааны тараах материалыг авсан, аяллын талаар ярилцсан хувь хүмүүсийн тоог нэмэх юм бол энэ тоо хэдэн зуугаар яригдах болно. Манай компанийн гадаадын нийт харилцагчдын 34 хувийг Герман хэлтэй улсуудаас байдаг. И Тэ Бэ үзэсгэлэнд оролцсоны дараа жуулчид ихэснэ гэсэн хүлээлт байна. Түүнтэй уялдуулаад гадаад, дотоод нислэгүүд, олон улсын галт тэргийн давтамжын тоог олшруулах, тогтмолжуулах хэрэгтэй. Жишээлбэл, дөрөвдүгээр сарын нислэгийн хуваарь одоо болтол гараагүй байна. Ялангуяа Европ жуулчдын хувьд жилийн өмнөөс төлөвлөгөө хийж, захиалга өгдөг. Гэтэл бидэнд тодорхой, тогтчихсон хуваарь одоо болтол байхгүй байгаа нь том хүндрэл учруулж байна. Энэ асуудалд шийдэл яаралтай хэрэгтэй байгаа. Бидний зүгээс хамтарч

ажиллаж буй компаниуд болон жуулчдынхаа хүсэлтийг харгалзаад үйлчилгээгээ чадах хэмжээндээ сайжруулаад явж байна.

#### **Ө.Золзаяа /“Селена Трэвел” компанийн ажилтан/:**

Манай компани тав дахь жилдээ оролцож байна. Шинэ түнштэй болох, хуучин түнштэйгээ харилцаагаа бататгах зорилгоор оролцдог. Манайх жилдээ 500-800 жуулчин хүлээн авдаг. Бид илүү үнэтэй аяллын багцыг санал болгодог учир тоо бус чанарт анхаардаг. Хэдийгээр манай компани англи хэлтэй орнуудын зах зээлээс жуулчид түлхүү авдаг ч Герман хэлтэй улсуудаас аялал авахын тулд И Тэ Бэд ордог. Ирэх тоолондоо 3-4 хамтарч ажиллаж болохуйц компанитай уулзаж хамтран ажиллах түвшинд ярилцаад буцдаг. Энэ жил 10 гаруй хуучин түнштэйгээ уулзсан бол шинээр 20 гаруй түнштэй боллоо. Тохиролцооны шатанд хүрсэн нэлээн хэдэн гэрээ байгаа. Манай хуучин түншүүдийн хувьд Монголыг түншээр оролцож байгаад ихээхэн талархалтай байгаа бөгөөд цаашид хамтарч ажиллахад илүү итгэл төрж байгаагаа бидэнд илэрхийлж байв. Шинэ түншүүдийн тухайд түншээр оролцох гэж байгааг сонсоод биднийг зорьж ирж байсан. Өмнөх жилүүдтэй харьцуулахад хүмүүсийн биднийг сонирхож ирж буй хандлага 10 дахин нэмэгдсэн гэж хэлж болно. Өнгөрсөн онуудад олон нийтэд үзэсгэлэнгээ сонирхуулдаг сүүлийн хоёр өдөрт манай сурталчилгааны талбай хоосон, хүнгүй шахам байдаг байлаа. И Тэ Бэ-д нэг жил ороод шууд л амжилт олно гэж байхгүй. Хоёр гурван жил оролцож байж томоохон аялал жуулчлалын компаниудын нүдэнд тусдаг. Гаднын компаниуд аливаа компаниудтай харилцаа тогтоохдоо тогтвортой үйл ажиллагаатай эсэхт өндөр ач холбогдол өгдөг. Манай шинэ, хуучин түншүүдийн хэлж байгаа нэг асуудал нь Монгол руу нислэг үйлдэхэд хүндрэл маш их. Үнэтэй, олдоц муутай гэдэг. Европын нислэгүүдийн давтамжийг нэмэгдүүлэх, чиглэлээ олшруулах шаардлага нэн тэргүүнд бий. Жуулчдын урсгалыг нэмэгдүүлэхийн тулд нислэгийн тоог нэмэгдүүлэх хэрэгтэй. ■

# “Иргэнд” хаягласан хууль эзэндээ хүрдэг болох нь

Ц.ЭЛБЭГСАЙХАН

Зайлшгүй, албан шахалтаар төлдөг хэрнээ тус нэмэр нь хэнд ч мэдрэгддэггүй даатгал бол Эрүүл мэндийн даатгал. Монголын Эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд алдаа дутагдал олон байгааг олон хүн ярьдаг, олон жишээ дурьддаг. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр хүн амын 80 гаруй хувь нь тус даатгалд хамрагддаг байна. Ер нь бол Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх ёстой.

Гэхдээ сайн бодвол бүгд төлөх ёстой, төлөөд байна уу гэхээр үгүй ч юм шиг. Тоон баримтаас харахад 18 хүртэлх насны иргэд, өндөр настнууд, цэргүүд, нярай хүүхэдтэй эхчүүд, эмзэг бүлгийнхэн гээд 1.3 сая иргэн Улсын төсвөөс даатгалаа төлүүлдэг юм байна. Энэ нь жилдээ 12.1 тэрбум төгрөг болдог аж. Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын зардлыг 100 хувь шахам аж ахуйн нэгжгийн эзэн, ажилтан, бизнес эрхлэгчид, оюутнууд, сайн дурын даатгалд хамрагддаг ажилгүй иргэд халааснаасаа гаргадаг байх нь. Яагаад вэ гэвэл Улсын төсвийн 80 орчим хувийг татвар бүрдүүлдэг юм.

Харин энэ жил ахиц дэвшил гарах болов уу гэсэн хүлээлт олон нийтэд байна. Хоёр жил дуншиж байж хэлэлцэгдсэн Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга өнгөрсөн нэгдүгээр сарын 29-нд батлагдсан. Шинэ хуулийн найруулгаар өмнө нь иргэдийн шүүмжилж байсан олон асуудал шийдэгдэх бодитой боломж бүрдсэн гэдгийг хууль санаачлагчид болон мэргэжлийн хүмүүс хэлж байгаа юм.

Тухайлбал, эрүүл мэндийн даатгалд баримталж байгаа эв санааны нэгдлийн зарчим нь өөрөө шударга

бус байгааг иргэд шүүмжилдэг байлаа. Учир нь даатгалын сангийн 80 хувийг аж ахуйн нэгжийн эздүүд, ажилтнууд, бизнес эрхлэгчдийн цалин, орлогоосоо төлсөн шимтгэл бүрдүүлдэг байна. Төсвөөс төлүүлж байна уу, цалингаасаа суутгуулж байна уу гэж ялгалгүй хэн ч байсан жилдээ 1.8 сая төгрөгтэй тэнцэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хөнгөлөлт авах эрхтэй бөгөөд сангийн нийт зардлын 56 хувийг төрөөс шимтгэлээ төлүүлдэг иргэдэд зарцуулдаг юм байна.

## ӨӨРӨӨ ТӨЛДӨГ, ӨМНӨӨСӨӨ ТӨЛҮҮЛДЭГИЙН ЗӨРҮҮ БАГАСЧЭЭ

Хуулийн шинэчлэлээр Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг 18 нас хүртэлх иргэд болон оюутан, сурагчид Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нэг хувиас доошгүй байх зохицуулалт хийсэн байна. Харин өөрөө хариуцан шимтгэлээ төлдөг бол Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний хоёр хувиас доошгүй байхаар тогтоожээ. Өөрөө төлдөг, өмнөөсөө төлүүлдэгийн зөрүү багасч, түүнийхээ хэрээр чанартай үйлчилгээ нэхэх эрх нь ч бүрдэж байна. Үүнийг дагаад эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгө нэмэгдэж, түүгээрээ хөнгөлөлт үзүүлдэг эм, эмчилгээний тоо, төрлийг нэмэх боломж бүрджээ. Тодорхой хэлбэл, өмнө нь хамрагдах боломжгүй байсан зургаан төрлийн эмчилгээг хөнгөлөлттэй авахаар болж байгаа юм.

### Үүнд:

-Хорт хавдрын болон бусад өвчний хөнгөвчлөх тусламж үйлчилгээ

-Өндөр өртөгтэй зарим тусламж үйлчилгээ, шаардлагатай эмнэлэгийн хэрэгсэл

-Зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгсэл

-Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ

-Хорт хавдрын хими болон туяаны өдрийн эмчилгээ

-Жирэмсний 37 хоногоос өмнөх ба төрсний дараах үеийн хавсарсан эмгэгийн эмчилгээ багтаж байна.

Мөн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын өмчийн хэлбэрээс хамаарахгүйгээр ижил тарифаар хөнгөлөлт үзүүлэхээр болж буй. /Өмнө нь хувийн хэвшлийн цөөн байгууллага даатгалын хөнгөлөлт үзүүлж байсан ч тариф нь ялгаатай байлаа/. Даатгуулагч чанар, үйлчилгээг өөрөө сонгох эрхтэй болж байна. Үүнээс гадна хуульд маш чухал нэг өгүүлбэр нэмэгджээ. Тэр нь “... эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад ороогүй тусламж, үйлчилгээ авах зорилгоор иргэн эрүүл мэндийн сайн дурын нэмэлт даатгалд даатгуулж болно” гэсэн заалт. Энд дурьдсан “сайн дурын нэмэлт даатгал” гэдгийг хувийн хэвшлийнхэн хийх юм. Ингэснээр эмчилгээний зардал өндөртэй, хэлж ирдэггүй өвчний өмнө бэлтгэлтэй байх боломж буй болж байна. Та албан журмын даатгалд заавал хамрагдах ёстой. Гэхдээ боломж нь хязгаарлагдмал, хөнгөлөлт нь чамлалттай санагдвал бусад эрсдэлээ даатгалын компаниудад давхар даатгуулах эрх нь нээлттэй болж байна. Цаашдаа хувийн хэвшлийнхний өрсөлдөөн

бий болж даатгалын үйлчилгээ иргэн рүүгээ чиглэдэг, хүрдэг болох “шав” тавигдаж байгаа юм.

### ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ ЭРХЭЭ ШИЛЖҮҮЛЖ БОЛНО

Энд орхигдуулж боломгүй бас нэг зүйл бий. Гэр бүлийн гишүүд хөнгөлөлт эдлэх эрхээ шилжүүлэх боломж бүрдүүлсэн явдал. Гэр бүлийн гишүүдийн нэг нь эрүүл мэндийн үйлчилгээ авах шаардлагагүй байхад нөгөөд нь тогтоосон хязгаараас илүү хөнгөлөлт хэрэгтэй байдаг. Тэгвэл шинэ зохицуулалтаар өмнө дурдсан эрүүл мэндийн даатгал бодитой хөнгөлөлт болж чаддаггүй байдал бага ч болов шийдэгдэж байна уу гэж харж байгаа юм.

Шинээр батлагдсан хууль ирэх долдугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ. Үүнээс өмнө амжуулах нэг том ажил бий нь Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан шинэ агентлаг бий болгох. Нэг үгээр хэлбэл, асуудал үүсэхэд хандах эзэн, очих хаягтай болж байна. Нөгөөтэйгүүр асуудал илүү чухал түвшинд тавигдах болсны илрэл. Энэ байгууллагыг


бий болгоход гурван тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө шаардлагатай гэсэн тооцоо хийсэн байдаг.

Шинэ агентлагийн ач холбогдлыг НДЕГ-ын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ц.Ганцэцэг хэлэхдээ энэ агентлагийг байгуулах хэдэн зайлшгүй шаардлага байгаа гэнэ. Хамгийн энгийн үндэслэлийг дурдвал одоогоор Эрүүл мэндийн даатгал хариуцсан нийт 120 орчим хүн гурван сая иргэнийг хамарч ажиллахаар зүтгэж байна. Харин шинэ агентлагийн салбар нэгжүүд хот, аймаг, сум бүрт байгуулагдсанаар иргэдэд хүрч үйлчлэхэд илүү дөхөмтэй болох аж. Эрүүл мэндийн даатгал бодит хөнгөлөлт болж чаддаггүй гэж шүүмжилсээр ирсэн болов ч нэг жилд давхардсан тоогоор 4.4 сая хүн хөнгөлөлт эдэлдэг гэлээ.

Мөн Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийн удирдлага хэтэрхий хуваагдмал байжээ. Тухайлбал, нэг даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний төрөл, хөнгөлөлт, эмнэлгүүдийн сонгон шалгаруулалт зэрэг сангийн хөрөнгийн зарцуулалтыг ЭМЯ шийдэж байхад орлого бүрдүүлэлтийг НДЕГ хариуцдаг байна. Тэднээс гадна ХАХНХЯ,

Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөл, Нийгмийн даатгалын салбар зөвлөл тус бүр өөрсдийн өгөгдсөн үүргээ хэрэгжүүлнэ. Буух эзэнгүй, буцах хаяггүй ийм байдалтай нэлээд удаан явж иржээ.

Энэ удаагийн шинэчилсэн найруулга хэрэгжсэнээр нийгэмд нэлээд хэдэн эерэг өөрчлөлт гарна гэж хууль санаачлагчид нь хүлээж байгаа юм. Тухайлбал, хуулийн нөлөөгөөр хүн амын эрүүл мэндийн байдал сайжирч, цаашдаа нийгэмд авчрах эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ, ядуурал буурна. Эмнэлгийн шаардлагагүй хэвтэлтийн тоо цөөрч, зардал хэмнэнэ. Ингэснээр бусад эрсдэлийг санхүүжүүлэх нөхцөл бүрдэж, даатгалын үр шимийг хүртэгчдийн тоо өснө гээд бас бус зүйл олон бий. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг 1993 онд анх өргөн барьж, дараа жилээс нь хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн байдаг. Өнгөрсөн хугацаанд есөн удаа өөрчлөлт орсон ч 2002 оноос хойш томоохон өөрчлөлт ороогүй, зөвхөн ганц хоёр зүйл заалт өөрчлөх, нэмэх зэрэг засвар хийгдэж иржээ. ■



## СЭТГЭЛГЭЭНИЙ ХУВЬСАЛ

## Ээ дээ, эрчүүд үү

## Ц.ЭЛБЭГСАЙХАН

Яаж ч тоолсон юм, яагаад ч ярих болсон юм бүү мэд. Монголд нэг эрд гурван эмэгтэй ногддог гэсэн яриа нэлээд хэдэн жилийн өмнөөс гарах болсон. Заримдаа бүр тав гэх. Ер нь бол эмэгтэйчүүд харьцангуй олонх гэдэг нь үнэн. Гэхдээ арай ч гурав, дөрөв дахин гэж ярих хэмжээнд биш. Чухамдаа бол эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харьцаа 95:100 байгаа юм. Гэхдээ энэ тоо бидний хөндөх сэдэв биш.

Энэ удаа монгол эрчүүдийн үнэлэмж, үнэ цэнэ буурч байгаа тухай, өрх гэрийн тэргүүн гэж хүндэлдэг хүндлэл үгүй болж, цог золбоо, сүлд хийморьтой эр хүн гэдэг ойлголт улам бүр бүдгэрч байгаа тухай хөндье гэсэн юм. Тэгэхдээ бүсгүйчүүдээ дорд үзэхийг эс уриалав. Гол асуудал нь ЯАГААД ..?

Яагаад эрчүүдийн үнэ цэнэ өдрөөс өдөрт буурсаар байна вэ? Яагаад “эр хүн” гэдэг үнэлэмж үгүй болж байна вэ? Яагаад гэдгийн хариултыг олбол яаж гэдэг нь тодорхой болох болов уу хэмээн сэтгэж байна.

Жинхэнэ эр хүн гэж хэн бэ? гэдэг асуултад “Гүндүүгүй, хэр баргийн юмыг тоодоггүй. Ханхар биетэй, хараад суухад сайхан” гэж хариулах юм бол “тэнэгтсэн” болно. Яагаад гэвэл цаг үе өөрчлөгджээ. Энэ л асуултын хариулт юм болов уу. Дээрх асуултыг эрэгтэйчүүдээс асуувал нэгийг, эмэгтэйчүүдээс асуувал өөр нэгийг хариулна. Төрийн хошой шагналт хөгжмийн зохиолч, Ардын жүжигчин Н.Жанцанноров эрхмээс “будaa идэх” санаатай “эрчүүдийн үнэлэмж яагаад буураад байгаа юм бол?” хэмээн асуутал “за одоо, эмэгтэйчүүд үнэлэхгүй байгаа болохоор л тэр байлгүй дээ” хэмээн ёжлов. Сайтар тунгаавал, түүний үнэн ажээ. Тийм бол яагаад эмэгтэйчүүд үнэлэхгүй байна вэ?

Үүний адилаар цөөн хэдэн эмэгтэйгээс асуувал тэд бараг нэг ижил зүйл ярьж байна. Монгол залуус соёлгүй бүдүүлэг, боловсролгүй, ажилгүй, унхиагүй гэдэг хариулт л тэднээс сонслоо. Тэдний зөв болохыг ч зарим статистик тоо батлаад байгаа юм. Ажил анхианы талаар авч үзье л дээ. 2014 оны дөрөвдүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 7.7 хувьтай байжээ. Тэгвэл эрчүүдийн хүрээнд авч үзвэл энэ тоо 8.1 хувь болж өсч байна. Эсрэгээрээ эмэгтэйчүүдийн 7.2 хувь нь энэ хугацаанд эрхэлсэн ажилгүй байжээ. Нөгөө “олонх” маань энд цөөнх болж хувирч байна. Эцсийн дүндээ улс орны эдийн засгийн хөгжилд эмэгтэйчүүд илүү хувь нэмэр оруулж, чухал үүрэг гүйцэтгэж байгааг энэ тоо өгүүлж байгаа юм.

Дараагаар нь боловсролын асуудал. Эрчүүдтэй харьцуулахад бүсгүйчүүд илүү боловсрол, мэдлэгтэй анхаардаг. Дээд боловсрол эмзэмшиж буй эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа 1.4 байна. Энэ нь таван оюутны хоёр нь эрэгтэй болохыг илэрхийлж байгаа юм. Цаашлаад их, дээд сургууль төгсөгчдийн тоог харах юм бол бүр багасч гурван оюутны нэг нь болж буурч байх жишээтэй. Монгол эмэгтэйчүүдийн дайчин, эрэмгий чанарыг гадаадынхан, олон улсад шагшиж байхад эрчүүдэд нь эхэлснээ дуусгах тууштай чанар алга. Ингэхлээр



эрчүүдийн масс боловсролоороо эмэгтэйчүүдийн “хаана ч хүрэхгүй” болж эмэгтэйчүүд мэдлэг боловсролгүй эр хүнийг үнэлэхгүй байна.

Соёлын тухайд гэвэл “муусайн” эрчүүдийг өөлөх мянган шалтгаан эмэгтэйчүүдэд олдож байна. Ерөөс аль ч түвшинд эрчүүдийн соёл “ноль” заадаг гэнэ. Гудамжаар явахдаа эмэгтэйчүүдэд зам тавьж өгдөггүй (бараг л мөргөж унагаад явдаг), хаалгаар орохдоо өөрөө түрүүлж орчихоод тас хийтэл хаачихдаг, энд тэндгүй шүлсээ хаяна, эмэгтэй хүн хүнд жинтэй юм өргөөд дааж ядан явахад хэнэг ч үгүй дээгүүр хараад өнгөрнө (зарим нь эхнэртээ хүүхдээ тэврүүлчихээд дээрээс нь цүнх хүрмээ бариулчихаад утсаар яриад, инээд алдаад алхдаг гэнэ шүү!). Тэгэхээр одоо жинхэнэ эр хүн гэж хэнийг хэлэх вэ? гэж асуувал “Боловсролтой, мэргэжилтэй, эмэгтэйчүүдийг хүндэлдэг, боловсон, товчхондоо бол жентелмэн” гэж хариулах хэрэгтэй. Үүнийг сонсоод “би чинь гүндүүгүй сайхан монгол эр, ямар англи, герман үндэстэн биш” гэж бодож байвал найз минь андуурч байна. (Цаг өөрчлөгдсөн байна шүү дээ).

Өмнө өгүүлсэнтэй холбон тайлбарлахад эрчүүд, эмэгтэйчүүдээс арай цөөн байгаа нь насжилттай холбоотой. Эрэгтэй хүмүүсийн дундаж наслалт 65 байхад эмэгтэйчүүд арван жилээр илүү наслаж байна. Харин эрчүүдийн эмэгтэйчүүдийг давж гарч байгаа ганц зүйл юу гээч... ял шийтгэл. Жил бүр шүүхийн байгууллагаар шийтгэл хүлээж байгаа хүмүүсийн 92, 93 хувь нь эрчүүд. Ингээд л эрчүүд нийгмийн амьдралаас “хол хаягдаад” байгаа нь нотлогдоод байгаа юм. Одоо эрчүүд минь, залуус минь ухамсраа өөрчлөх цаг болжээ. Хий хоосон улс төржилтөө орхиж, улс эх орондоо хэрэгтэй үйл бүтээлцье. Ачааны хүндийг үүрч яваа бүсгүйчүүдээ тус нэмэр болцгооё. Боловсролдоо анхааръя, нийтийн соёлд суралцъя. Товчоор хэлбэл өөрийнхөө үнэлэмжийг дээшлүүлж, үнэ цэнээ тогтоох цаг ирчихээд байна. ■

## “MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

**Таны бодлоор эр хүний ноён нуруу гэж юу вэ. Монгол эрчүүдийн энэ шинж орчин үед хэрхэн өөрчлөгдөж байна. Юу дутагдалтай байна вэ?**



**Д.ДАГВАДОРЖ** /Японы мэргэжлийн сумо бөхийн 68 дахь их аварга/

Бусдын хэтэвчийг өнгийж харахгүй өөрийн бие мах бодио дайчлах. Гурвын цаана дуугардаг хүн байх хэрэггүй.

**М.ЗОРИГТ УИХ-ын гишүүн**

Нэг нүүртэй байх л гэж ойлгож ирсэн.

**Ц.ХЭНМЭДЭХ** Монгол Улсын Тод Манлай уяач

Эр хүний ноён нуруу гэж болж байгаа цагтаа онгирч сагсуурдаггүй, болохоо байлаа гэхэд гуниж гутардаггүй явахыг л хэлнэ дээ. Үгүй байг гэхэд хүнд тус болдоггүй юм аа гэвэл гай болдоггүй байх л ноён нуруу даа. Цаашлах юм бол хонхортоо хочгүй явахыг л ноён нуруу гэж ярина. Нэг удаа радиогоор Тод Манлай уяач Д.Ононгоос та сайн хүн үү, муу хүн үү гэж асуутал “Би сайн мэдэхгүй юм. Хонхрынхон маань л мэдэж байгаа байх даа. Хонхортоо хочгүй хүнийг л сайн хүн гэнэ гэж Хэнмэдэх гуай ярьдаг юм” гэж байсан. Тэгэхээр миний хэлсэн үг залуучуудад хүрдэг юм болов уу даа гэж бодож байна.



**АРТГАА** /жиргээч, нийтлэлч/

Цэцэрлэг, дунд/ахлах сургуульд нь зохих хичээл орохгүй байгаагаас болж ноён нуруугүй монголчууд улам олон болж байна. Гэрийн хүмүүжлээрээ л явж байна. Тэгээд нийгэм нь адгуу зантай, түргэн ууртай, асар их омогтой зан нь монгол эрсийг үнэхээр ноён нуруугүй харагдуулж байна. Ганц үг даах нуруутай хүн байхгүй манайд. Өрвөлзөө л “ална” гээд босоод ирнэ. Ноён нуруу гэж байхгүй. Багаас нь системтэй заахаас нааш бүткү. Алдаагаа давтдаггүй, үг үйлдэл даагаад өнгөрөөчихдөг, асуудлыг том харах, эмэгтэй хүнийг хүндлэх, хүүхдийг энэрэх, ёс уламжлалаа мэддэг байх зэргээс эхлээд архи тохируулаад сайхан хэрэглэх, авгай хүүхнийг сайхан эргүүлэх хүртэл эр хүний ноён нурууг илэрхийлнэ шүү дээ.



**Д.ТӨРМӨНХ** /Зохиолч, найруулагч/

Ерөнхийдөө ноён нурууны тухай ганц өгүүлбэрээр хариулах аргагүй. Ноён нуруу гэж маш товчоор хэлбэл хариу үйлдэл хийгээд байхгүй тэгш амгалан орших чадвар юм шиг. Эр хүн зовлон жаргал алиныг ч зүгээр л эсэргүүцээд байхын оронд хүлээгээд авчихдаг байвал ялангуяа зовлон уужим сэтгэлийн орон зайд уусаж алга болдог. Хүлцэнгүй бай гэсэн үг биш. Хүлээж авч чаддаг байхыг л хэлээд байх шиг. Хариу үйлдэл хийж өрвөлзөхөө уртал болгоод байна.

